

ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Гүйцэтгэгч: ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦООНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

Боловсруулсан:

Д.Ууганбаяр

/Хүүхдийн хөгжил, оролцооны үндэсний сүлжээний зохицуулагч/

Ц.Эрдэнэчимэг /Нийгмийн ажлын хөгжлийн төвийн багш Ph.D/

Хянасан:

Н. Оюунчимэг

/ГБХЗХГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын дарга/

С.Болорцэцэг /Сургалт, судалгаа мэдээллийн төвийн захирал/

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
I БҮЛЭГ. УДИРТГАЛ	6
1.1. Үндэслэл	6
1.2. Зорилго, зорилт	7
1.3. Судалгааны арга зүй	9
II БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХУУЛЬ ЭРХҮЙН ЗҮЙН ХАМГААЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД	10
2.1. Хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тухай үндсэн ойлголт, олон улсын эрх зүйн хамгаалалт	10
2.2. Үндэсний эрх зүйн хамгаалалт, хүүхдийн оролцоог хангахад оролцогч талууд, тэдний үүрэг	14
III БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	31
3.1. Сэдвийн судлагдсан байдал	31
3.2. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тайлан илтгэл, зөвлөмж	34
3.3. Хүүхдийн оролцооны нөхцөл байдлыг үнэлэх нь	41
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	75
НОМ ЗҮЙ	78
ХАВСРАЛТ	81

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1 УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газрын бүрэн эрх

Хүснэгт 2.2 Хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад оролцогч талууд 9

Хүснэгт 3.1 Хүүхдийн оролцооны талаар хүүхдүүд болон насанд хүрэгчдийн ойлголт

Хүснэгт 3.2 Хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудлууд

Хүснэгт 3.3 Танд өөртөө хамааралтай бүхий л асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, оролцоход ямар бэрхшээл тулгардаг вэ?

График 1.1 Хүн амын нас хүйсийн суварга (0-17)

График 3.1 Судалгаанд оролцогчдын нас

График 3.2 Судалгаанд оролцогчдын хүйс /Насанд хүрэгчид/

График 3.3 Хүүхдүүдийн нас хүйс /2019 он/

График 3.4 Хүүхдийн оролцоог гэр бүлийн хүрээнд дэмждэг эсэх

График 3.5 Сургуулийн дүрэм, журам шийдвэрт хүүхдүүд оролцож чаддаг эсэх

График 3.6 Хүүхэд өөрийн сайн дураар оролцдог эсэх

График 3.7 Хүүхдүүд төлөөллөө өөрсдөө сонгодог эсэх

График 3.8 Хүүхэд хэвлэл мэдээллээр дамжуулах үзэл бодлоо илэрхийлэх боломжтой эсэх

График 3.9 Хүүхэд эрх нь зөрчигдвөл хэнд хаана хэрхэн хандахаа мэддэг эсэх

График 3.10 Таны эрх зөрчигдсөн үед хаана хандах вэ?

График 3.11 Хандах сувгийн тоо

График 3.12 Хүүхэд шийдвэр гаргагчид захиа бичих, уулзах боломжтой эсэх

График 3.13 Хөндлөнгийн нөлөө, дарамтгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХНЗ	АЙМГИЙН ХҮҮХДИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ
БХАН	БОЛОВСРОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ
ГБХЗХГ	ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
ДЗОУБ	ДЭЛХИЙН ЗӨН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МУЗН	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГ
НА	НИЙГМИЙН АЖИЛТАН
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
НҮБХС	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН
ОУБ	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
СӨУЗ	СУРАГЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХОУЗ	ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ХӨУБ	ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА
ЯХИС	ЯПОНЫ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХНЗ	АЙМГИЙН ХҮҮХДИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ
БХАН	БОЛОВСРОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ
ГБХЗХГ	ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
ДЗОУБ	ДЭЛХИЙН ЗӨН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
МУЗН	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГ
НА	НИЙГМИЙН АЖИЛТАН
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
НҮБХС	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН
ОУБ	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
СӨУЗ	СУРАГЧДЫН ӨӨРӨӨ УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХОУЗ	ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ХӨУБ	ХҮҮХДИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА
ЯХИС	ЯПОНЫ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

I БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1. ҮНДЭСЛЭЛ

Монгол улс 1989 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд 2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталж хүүхэд хамгааллын тогтолцоо, оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлсон. Хүүхдийн эрх тэр дундаа хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд энэхүү эрхийг нийгмийн бүхий л орчинд хангах нь хүүхэд өсвөр үеийнхний чадавхад, нийгмийн хөгжилд ч эерэгээр нөлөөлдөг. Төрийн дөрвөн шатлалт үүрэг бол хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх, хүний эрхэд ахиц гаргах бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж үзэх, хүүхдийн амьдралын бүхий л талбарт утга учиртай оролцоог хангахад төрийн үүрэг оролцоо нэн чухал юм.

Монгол улсын хүн амын 37%-ийг 0-18 насны хүүхэд эзэлдэг бөгөөд өсвөр насны хүүхдийн бие даах чадварыг хөгжүүлэх, тэдний утга учиртай оролцоог дэмжих нь ирээдүйд чадвар, чадамж бүхий иргэнийг төлөвшүүлэхэд чухал холбогдолтой.

График 1.1 Хүн амын нас хүйсийн суварга (0-17)



Эх сурвалж: эх сурвалж: 1212.mn

Насанд хүрэгчдийн гаргасан шийдвэр хүүхдүүдийн амьдралд янз бүрээр нөлөөлдөг боловч хүүхэд өөртөө хамаатай аливаа шийдвэрт санал бодол, дуу хоолойгоо хүргэх боломж бодит байдалд хомс байна гэж 2017 онд Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газраас хийсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд оролцсон хүүхдүүдийн 87.4 хувь нь үзсэн байдаг.¹ Мөн хүүхдийн нийгэмшил, хүмүүжлийн анхдагч орчин болох гэр бүлийн орчин, сургуулийн орчинд ч хүүхдийн оролцоо хангалттай сайн биш байгаа нь судалгаанаас харагддаг. Хүүхдийн эрхийн тухай конвенцын тайлан илтгэлүүдэд Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжүүдэд хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх талаар тодорхой зөвлөмжүүдийг өгсөн байдаг бөгөөд гэр, сургууль, орон нутаг, халамж асрамжийн байгууллага, шүүхийн болон захиргааны шийдвэр зэрэг хүүхдэд нөлөөлж буй бүх асуудалд хүүхдийн оролцоог дэмжиж, цаашид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг сахин, хэрэгжүүлж, дэмжих тал дээр хүчин чармайлт гаргахыг зөвлөсөөр ирсэн ч энэ чиглэлээр тодорхой ахиц үр дүн гарахгүй байна. Иймд хүүхдийн хөгжил оролцооны өнөөгийн байдлыг үнэлэх, хууль эрхзүйн орчинд дүн шинжилгээ хийх, хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад тулгарч буй бэрхшээл сорилтыг тодорхойлох, цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал дэвшүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.2. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү зураглал, судалгааны ажлын зорилго нь хүүхдийн оролцооны өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчин, хүүхдийн оролцоог хангахад оролцогч талууд, тэдний үүрэг оролцоо, энэ чиглэлээр ажиллаж байгаа засгийн газрын бүтэц, удирдлага, зохион байгуулалт, хүүхдийн оролцооны нөхцөл байдлыг үнэлэх, зураглалыг гаргах, зөвлөмж боловсруулахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх хэмээх ухагдахууны үндсэн ойлголт, тодорхойлолт, олон улсын болон дотоодын хууль эрх зүйн орчныг судлах
- Хүүхдийн оролцоог хангахад оролцогч талууд, тэдний үүрэг оролцоог тодорхойлох
- Хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр ажиллаж байгаа бүтэц тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлох

¹ “Өсвөр үеийнхний дуу хоолой-1”, Японы Хүүхдийг Ивээх Сан. 2017

- Хүүхдийн амьдралын бүхий л орчинд хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх
- Хүүхдийн оролцооны системийн зураглалыг гаргах, оролцох эрхийг хангах зөвлөмж боловсруулах

1.3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны үндсэн арга нь баримтын шинжилгээ, асуулга, фокус бүлгийн ярилцлагын аргыг хэрэглэсэн. Баримт бичгийн шинжилгээний хувьд хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрх, хүүхдийн оролцоог хангах чиглэлээр хууль эрх зүйн орчин, дүрэм журам, бодлогын баримт бичиг, Хүүхдийн эрхийн тухай конвенцын тайлан илтгэл зөвлөмж, бусад байгууллага судлаачдын хийсэн судалгаа, шинжилгээний бүтээлийг судлан, мэдээллийн дүн шинжилгээ хийсэн.

1. Асуулга, ярилцлагын хувьд: 2018 оны 06 сарын 16-19-нд “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцсон 680 хүүхдээс 8 асуулт бүхий анкетаар судалгаа авсан. Мөн хүүхдүүдийн нэмэлт саналыг нээлттэй самбараар болон бичиг (захидал) -ээр авч үр дүнг нэгтгэсэн.
2. Хүүхдийн оролцооны зураглал гаргах судалгааг “хүүхдийн амьдралын бүхий л талбарт” хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх боломж байгаа эсэх, хүүхдийг хүндэлдэг эсэх, хүүхдийн оролцооны чанар цар хүрээ, хүүхдийн оролцох эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин, оролцох эрхийн талаар мэдлэг, ойлголт, оролцох эрмэлзлийг хөхүүлэн дэмжих, оролцох орчин нөхцөл орон зай бүрдүүлэх хүрээнд асуулгын аргыг ашиглан 2019 оны 11-р сарын 5-22-ны өдрүүдэд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн насанд хүрэгчдээс 100, хүүхдээс 497 анкетын мэдээллийг тус тус цуглуулсан байна. Үүнд:
 - Насанд хүрэгчдийн асуулгын судалгаанд орон нутгийн шийдвэр гаргах түвшний төлөөлөл, баг хороо, боловсрол, эрүүл мэнд, шүүх, хүний эрхийн байгууллага, эцэг эх, хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг сонгогдсон аймаг/дүүрэг тус бүрээс 5 хүнийг хамруулсан.
 - Хүүхдийн асуулгын судалгаанд улсын болон хувийн ерөнхий боловсролын сургууль, тусгай хэрэгцээт сургууль, сүм хийд, асрамж халамжийн төв гэсэн төлөөллөөс сонгогдсон аймаг/дүүрэг тус бүрээс 11-15, 16-18 насны нийт 28 хүүхдийг хамруулсан.

- Хүүхдийн оролцооны талаарх талуудын байр суурь, ойлголт, өнөөгийн нөхцөл байдал, асуудлуудын талаар тодруулах зорилгоор фокус бүлгийн ярилцлага хийсэн.
- Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагыг Төв, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Өмнө-Говь аймаг, Чингэлтэй, Баянзүрх дүүрэгт нийт 6 удаа 60 хүнтэй хийсэн бөгөөд 40 эмэгтэй, 20 эрэгтэй хүн хамрагдсан.
- ЕБС-ийн сурагчдын дунд фокус бүлгийн ярилцлагыг Говь-Алтай, Төв, Завхан, Баянхонгор, Увс аймаг Баянзүрх, Чингэлтэй дүүргийн төлөөлөл тус бүр 10 нийт 70 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Ярилцлагад 7-18 насны 29 эрэгтэй, 41 эмэгтэй хүүхэд хамрагдсан.

II БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗҮЙН ХАМГААЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД

2.1. ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулиар “Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 насны хүнд энэ хуульд заасан тусламж үйлчилгээг үзүүлж болно”² гэж заасан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын үзэл санааг бүрдүүлж байдаг дөрвөн үндсэн зарчим байдаг бөгөөд тэдгээр нь бусад эрхүүдийг тайлбарлах үндэс болж өгдөг. Эдгээр зарчмуудын нэг нь оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрх юм. Конвенцийн 12-р зүйлд “Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө. Энэ зорилгоор өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд шууд, эсвэл үндэсний хууль тогтоомжид заасан журмын дагуу төлөөлөгчөөр буюу зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгоно”³ гэж заасан. Энэ зарчмын онцлог нь хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ба хүүхдийг сонсох ёстойг шаарддаг.

Хүүхдийн дээд ашиг сонирхлыг дээдлэн, хүүхдэд ээлтэй нийгмийг байгуулах нөхцөлийг хангахын төлөө Засгийн газар, олон нийтийн ба хувийн салбарынхан өөрсдийн үйл ажиллагааг хүүхдэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхой болгох ёстойг Хүүхдийн эрхийн тухай конвенцид мөн онцлон тэмдэглэсэн. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг тодорхойлохын тулд хүүхэд бүрд тухайн үйл ажиллагааны хэрхэн нөлөөлж буйг нарийн авч үзэх ёстой. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3-р зүйлд “хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна”⁴ гэж заасан.

² Хүүхэд хамгааллын тухай хууль

³ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц 12-р зүйл

⁴ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц 3-р зүйл

Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхэд бол идэвхгүй, хамгаалал халамж хүлээн авагч биш, харин хөгжин төлөвшиж байгаа чадавхынхаа хирээр өөрсдөд нь нөлөөлөх шийдвэрүүдийг гаргахад оролцох эрх эдлэгчид гэж үздэг. Түүнчлэн өөрсдийнхөө төлөө ухамсартай шийдвэр гаргах эрхтэй, тэр шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай эрх эдлэгчид гэж үздэг.⁵ Конвенцийн дараах заалтуудад хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байдаг. Үүнд:

- 5-р зүйл: Эцэг эхийн удирдлага ба хүүхдийн өсөн хөгжиж буй ур чадвар чадамжийг анхаарах
- 9-р зүйл: Хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг эхээс нь салгахгүй байх үүрэг
- 12-р зүйл: Өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах
- 13-р зүйл: Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
- 14-р зүйл: Шашин шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх эрх
- 15-р зүйл: Эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах
- 16-р зүйл: Хувийн нууц, нэр төр, алдар хүндээ хамгаалуулах
- 17-р зүйл: Мэдээлэл олж авах эрх
- 29-р зүйл: Хүний эрх, ардчиллыг хүндэтгэсэн боловсролыг эзэмших
- 42-р зүйл: Хүүхэд өөрийн эрхийг мэдэх эрх

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 5-р зүйлд хүүхэд эрхээ эдлэх явцад эх эцэг, асран хамгаалагчид нь удирдан чиглүүлэхдээ хүүхдийн төлөвшиж байгаа чадвар чадамжийг анхаарч байх шаардлагатай болохыг цохон заасан. Өөрөөр хэлбэл хүүхэд өсөж бойжихдоо чадвар, чадамж суудаг бөгөөд чадавх нь боловсрох тутам өөрсдөдөө нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах хариуцлага нь улам бүр өсөн нэмэгдэж байдаг гэдгийг ойлгож, анхаарах шаардлагатай. Конвенцийн 13–17-р зүйлд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, шүтлэгтэй байх ба итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, хуран цугларах, хувийн нууцаа хадгалах, хамгаалуулах, мэдээлэл авах зэрэг хүүхдийн эрхүүдэд чиглэгдсэн байна. Иргэний эрхийн энэхүү багцыг ерөнхийд нь “оролцоо” гэдэг өргөн утгатай нэр томъёогоор төлөөлүүлсэн байна. Хүүхдийн Эрхийн тухай Конвенцид өөрт нь “оролцоо” гэдэг нэр томъёо хэрэглэгдээгүй боловч Хүүхдийн Эрхийн Хороо болон хүүхдийн эрхийн төлөө ажилладаг дэлхийн бусад олон байгууллага эдгээр эрхийн хэрэгжилтийг товчлон тодорхойлох зорилгоор энэхүү нэр томъёог хэрэглэх болсон байна.

⁵ *Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд, Хүүхдийг Ивээх Сан. 2014*

Конвенцийн 12-р зүйл нь хүний эрхийн гэрээний онцгой заалт бөгөөд энэ нь зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуульчлаад зогсохгүй бусад бүх эрхүүдийг тайлбарлах, хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой. Конвенцид оролцогч улсууд хүүхдийг өөрийн үзэл бодолтой байхыг хөхиүлэн дэмжих, энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжтой орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхлын төлөө зайлшгүй шаардлагатай бүх мэдээлэл, зөвлөгөө авч шийдвэр гаргах бололцоогоор хангана гэж заасан. Гэхдээ хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эсэх нь хүүхдийн өөрийн сонголт болохоос зайлшгүй биелүүлэх үүрэг биш гэдгийг анхаарах ёстой.

Хүүхдийн оролцоо яагаад чухал вэ? Оролцоо нь хүүхдийн бусад эрхийг хэрэгжүүлэх арга зам болдог. Охид хөвгүүд идэвхтэй оролцооноор өөрсдийн амьдралын талаар мэдээлэл, ойлголт өгч, энэ нь тэдэнд хамаатай бодлого, үйл ажиллагааг оновчтой болгох, бусад эрхүүдийг хэрэгжүүлэхэд тусалж байдаг. Хүүхэд оролцох явцдаа чадвартай, мэдлэгтэй, чадамжтай, итгэлтэй болдог. Мөн оролцооноор тэд аливаа дарамж, шахалт, эрсдэл, хүчирхийллээс өөрийгөө хамгаалах боломжтой болж аюулгүй байдал баталгааждаг. Оролцоо нь иргэний оролцоо, идэвхтэй иргэн байхыг дэмждэг ба хариуцлага хүлээх зарчим, сайн засаглалыг төлөвшүүлэхэд тустай.⁶ Тиймээс хүүхдийн оролцоо нь гэр бүл, сургуулийн орчин, олон нийтийн орчинд хүүхдийн бусад эрхээ эдлэх урьдчилсан нөхцөл болж өгдөг. Оролцоо нь хүүхдийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 12 дугаар Ерөнхий зөвлөмжид (2009) Хүүхэд оролцож, санал бодлоо илэрхийлж байгаа бүх үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавьсан.

Үүнд:

Ил тод, мэдээллээр хангасан байх – хүүхдүүдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнд зохих ач холбогдол өгөх болон хэрхэн оролцох хүрээ, зорилго, боломжит үр нөлөөний талаар хүртээмжтэй, олон талт, тэдний насны онцлогт тохирсон мэдээллээр хангах ёстой;

Сайн дурын байх – хүүхдүүдийг өөрсдийнх хүсэл зоригоос ангид үзэл бодлоо илэрхийлэхийг албадах ёсгүй бөгөөд оролцооны аль ч шатанд өөрсдөө татгалзаж болох талаар тэдэнд мэдэгдэх нь зүйтэй;

Хүндэтгэсэн байх – Хүүхдүүдийн үзэл бодлыг хүндэтгэн үзэх ёстой бөгөөд тэднийг шинийг санаачлах, эрэлхийлэх боломжоор хангах;

⁶ Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд: Товхимол 1 Танилцуулга. Хүүхдийг Ивээх Сан.

Холбогдолтой байх – Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх асуудал нь тэдний бодит амьдралтай холбоотой асуудлаар байх бөгөөд өөрсдийн мэдлэг, дадал, чадвар дээр тулгуурлах боломжтой байх нь чухал. Мөн түүнчлэн, хүүхдүүдийн өөрсдөө чухал ач холбогдолтой гэж үзсэн асуудлаа тодорхойлох, онцлон тэмдэглэх эрх эдлэх бололцоогоор хангах;

Хүүхдэд ээлтэй байх – Хүрээлэн буй орчин, ажлын арга барил нь хүүхдийн чадвар, чадамжид нийцсэн байх учиртай. Хүүхдүүдийг үзэлт бодлоо төгс илэрхийлэхэд бэлдэх хангалттай цаг хугацаа болон нөөц бололцоогоор хангах ёстой.

Тэгш эрхтэйгээр оролцуулах – хүүхдийн оролцоо нь ялгаварлан гадуурхах, алагчлахын аль ч хэлбэрээс зайлсхийсэн, эмзэг бүлэгт хамаардаг хүүхдүүдэд боломж олгохыг хөхиүлэн дэмжих, охид хөвгүүдийг тэгш эрхтэйгээр оролцуулсан байх ёстой.

Сургалтад хамруулах – Хүүхдийн оролцоог тэдний хөгжиж буй чадавхад нийцүүлэхэд үр дүнтэй хэрэгжүүлэх, тухайлбал бусдыг сонсох, бусад хүүхдүүдтэй хамтран ажиллах дадалд сургахад насанд хүрэгсдийг бэлтгэх, дадал олгох, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Эрсдэлээс хамгаалагдсан, эрсдэлд мэдрэмтгий байх – хүүхэд тодорхой нөхцөл байдалд үзэл бодлоо илэрхийлэх нь тэднийг эрсдэлд оруулах магадлалтай байдаг. Хүүхдүүдтэй ажилладаг насанд хүрэгсэд тэдний оролцооноос үүдэн гарч болзошгүй хүчирхийлэл, мөлжлөг гэх мэтээр эрсдэл эсхүл бусад сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээ авах ёстой.

Хариуцах чадвартай байх – Дараагийн хийх ёстой ажлын талаарх амлалт гаргах болон өмнөх ажилд үнэлэлт өгөх нь нэн чухал. Жишээлбэл: ямар ч судалгаа, зөвлөгөөний явцад хүүхдүүдэд тэдний үзэл бодлыг хэрхэн харгалзан үзсэн талаар мэдээлэх, шаардлагатай бол тухайн судалгааны үр дүнд нөлөөлөх, маргах бололцоогоор хангасан байх ёстой.⁷

Конвенцийн 12-р зүйлд үндэслэн хүүхдийн оролцоог дараах төрлүүдэд хуваадаг. Үүнд:

Зөвлөлдөх: Насанд хүрэгчид аливаа асуудлаар хүүхдийн санал бодлыг сонсож ярилцах үйл явцыг зөвлөлдөх гэж нэрлэнэ. Энэ нь ихэвчлэн томчууд санаачилж, удирдаж чиглүүлдэг учраас хүүхдэд шийдвэр гаргах үр дүнд нөлөөлөх боломж хомс байдаг.

Түншлэх замаар хамтрах: Төсөл, хөтөлбөр санаачлах, боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийхэд томчууд хүүхдүүд хамтран ажиллах, хүүхдийг дээрх үе шатуудад идэвхтэй оролцох боломжоор хангах

⁷ Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны Ерөнхий Зөвлөмж № 12 (2009)

Хүүхэд удирдсан: Хүүхэд өөрт хамаатай асуудлыг тодорхойлж үйл ажиллагааг санаачилж хэрхэн хэрэгжүүлэхийг шийдэх боломжтой байх; энэ тохиолдолд томчууд удирдах бус хүүхдүүд өөрсдөө үйл явцыг хянадаг.

Аливаа төсөл хөтөлбөрийн үе шат бүрд, тухайлбал: нөхцөл байдлыг үнэлэх, судлах, төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх зэрэгт охид хөвгүүд эхнээс нь оролцох утга учиртай оролцоо болох бөгөөд энэхүү оролцоог хангахын тулд тэдний нас сэтгэхүй, чадамж хэл соёлын онцлогт тохируулан мэдээллээр хангах хэрэгтэй.

2.2. ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ, ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДНИЙ ҮҮРЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн (1990) 16 дугаар зүйлийн 16-д “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг, 10-д “Монгол Улсын иргэн бүр нийгмийн болон өөрсдийн эрх ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн (2016) 4.1.-д Хүүхдийн эрхийг хамгаалахад дараах зарчмыг баримтална гэж заасан. Үүнд: хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх; төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах; хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах; хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах; хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах гэж заасан.

Хүүхдийн хөгжил, эрхийн талаарх хуулийн зүйл ангийн 6.1.-д “Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх” бөгөөд хүүхэд хүүхдийн хөгжилтэй холбоотой дараах эрх эдэлнэ гэжээ. Үүнд: 6.1.1.хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших; 6.1.2.хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших; 6.1.3.хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах; 6.1.4.хүүхэд шашин шүтэх, эс шүтэх; 6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах; 6.1.6.хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх эрх эдэлнэ гэж заажээ.

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийн талаар ХЭТХ-ийн 8-р зүйлд: “хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон, хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх; хүүхэд өөрт хамаарах

аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох; хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх; хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах; хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах” эрхтэй гэж заасан.

Хүүхдийн эрхийг хангах төрийн захиргааны бүтэц, үүрэг оролцоо


Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3-р бүлэгт төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоог тодорхойлж өгсөн. Хүүхдийн оролцоо нь бие даасан хүүхдийн эрх болохын хувьд хүүхдийн эрхийг хангах үүрэг хүлээсэн оролцогч талууд ч мөн хүүхдийн оролцоог дэмжих үүрэгтэй. Хүүхдийн эрхийг хангахад УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллага “бодлого тодорхойлох, төсөв батлах, хэрэгжилтэд хяналт тавих” үүрэгтэй, засгийн газар “төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хүүхдийн санаачилгыг дэмжих, тэмцээн, уралдаанд оролцоход нь дэмжих журам баталж хэрэгжүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Хүснэгт 2.1 УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газрын бүрэн эрх

<p>11. Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагууд, үүнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал хамаарна</p>	<p>хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох; хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах; хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжид хяналт тавих.</p>
<p>12. Засгийн газрын үүрэг оролцоо</p>	<p>12.1.1.хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах; 12.1.2.хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах; 12.1.3.хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 12.1.4.хүүхдийн амралт, чөлөөт цагийг хөгжилд чиглүүлэх бодлогыг дэмжих, 12.1.5.хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр ... уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам баталж, хэрэгжүүлэх; 12.1.6. шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулах</p>

Эх сурвалж. ХЭТХ, 2016

Хүснэгт 2.2 Хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад оролцогч талууд



Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл ба орон нутгийн зөвлөлүүд

Хүүхдийн эрхийн тухай хуульд Хүүхдийн төлөө үндэсний ба орон нутгийн зөвлөлүүдийн үүрэг, оролцоог зааж өгсөн. ХЭТХ-ийн 16.1.-д “Хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд, орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус тус тэргүүлнэ” гэж заасан ба зөвлөлийн ажлын албаны үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тусын чиг үүргийн дагуу гүйцэтгэнэ гэжээ. Тус хуулийн 17.1-д заасны дагуу бүх шатны Засаг дарга 17,1,1 тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийг тэргүүлэх; 17.1.2. харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах,

энэ талаар гарсан санал, санаачилгыг дэмжих, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах; 17.1.3. тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг.

ХТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын захирамжаар баталдаг. Одоогийн бүтцийг 2017 оны 3-р сард баталсан ба хүүхдийн оролцооны үндэсний сүлжээний зохицуулагч, нийслэлийн хүүхдийн холбооны тэргүүн гэсэн хүүхдийн 2 төлөөллийг тохиролцсоны үндсэн дээр оролцуулдаг ба эдгээр хүүхдүүдийг хүүхэд өөрсдөө сонгох, ХТҮЗ-д эдгээр хүүхдийн дуу хоолойг сонсох механизм хангалтгүй гэж хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл үзэж байв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Монгол Улсын Их хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн Газрын 4 дүгээр тогтоолоор анх удаа төрийн үндсэн бүтцэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар 90 жилийн түүхтэй Хүүхдийн төлөө үндэсний газрыг түшиглэн байгуулсан. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) нь Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд Ерөнхий сайдын тэргүүлсэн Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Залуучуудын хөгжлийн Үндэсний зөвлөл (“Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн төсөлд тусгагдсанаар)-ийн ажлын алба байна. Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх талаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Залуучуудын хөгжлийн Үндэсний зөвлөлийн өмнө үүрэг, хариуцлага хүлээнэ.

<p>13. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо, үүнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хамаарна</p>	<p>13.1.1. хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцах;</p> <p>13.1.2. хүүхдийн эрхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийн Засгийн газрын тайланг боловсруулж, Засгийн газарт танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, олон улсын байгууллагын зөвлөмжийг олон нийтэд сурталчлах, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>13.1.3. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>13.1.4. хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, хүүхдийн санал, санаачилгаар бий болсон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг төсөвт тусгаж батлуулах;</p> <p>13.1.5. хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих;</p> <p>13.1.6. хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хүүхдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд үнэлгээ өгөх; ...</p> <p>13.1.8. хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах.</p>
<p>14. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо</p>	<p>14.1.1. хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>14.1.2. хүүхдийн эрхийг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>14.1.3. орон нутгийн салбар, нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, бусад байгууллагын уялдаа холбоог зохицуулах, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх;</p> <p>14.1.4. хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хяналт тавих;</p> <p>14.1.5. хүүхдийн асуудал эрхэлсэн бүх шатны ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>14.1.6. хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;</p> <p>14.1.7. хүүхдийн эрхийг хангахад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж урамшуулах;</p> <p>14.1.8. хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, байр танхимаар хангах;</p> <p>14.1.9. хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>

<p>15. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо</p>	<p>15.1.1. тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>15.1.2. тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;</p> <p>15.1.3. эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;</p> <p>15.1.4. хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;</p> <p>15.1.5. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн тухайн шатны байгууллага, ажилтан нь хүүхэд, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангах, шаардлагатай бол сургалт зохион байгуулах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>15.1.6. энэ хуулийн 14.2-т заасан журмын дагуу анхан шатны байгууллага, ажилтан, хамтран ажиллаж байгаа хуулийн этгээдээс мэдээ тайлан авч, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хянах, холбогдох мэдээллийг нэгтгэн төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>15.1.7. хүүхэд гишүүнчлэлтэй болон эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин, байр, танхимаар хангах;</p> <p>15.1.8. хүүхдийн эрхийн чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</p>
--	---

Эх сурвалж. ХЭТХ, 2016

Хүүхдийн эрхийн байцаагч

Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарыг бэлтгэх сургалтыг 2017 онд зохион байгуулж, шалгуур хангасан 38 ажилтанд улсын байцаагчийн эрх олгосон. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн эрхийн байцаагчийн үйл ажиллагааг хуульчилсан бөгөөд Монгол улсын Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийг шалган шийдвэрлэх эрхтэй. Тухайлбал, хүүхдийн эрхийн улсын байцаагч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар хүүхдийн эсрэг зөрчил, хүүхэд харах үйлчилгээ, төрийн албатай холбоотой гурван зүйлийн зөрчлийг шалган шийдвэрлэдэг. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 6.20.1-8 заалтын дагуу хянан шалгах ажиллагаа явуулж, торгууль шийтгэл оногдуулах, зөрчилд хариуцлага тооцохоос гадна хүүхдийн эрхийн зөрчлийг бүртгэх, шийдвэр гаргагчдад мэдээлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж ажилладаг.

Зөрчлийн тухай хуулийн дагуу улсын байцаагч нар хүүхдийн эрхийн эсрэг 16 төрлийн зөрчилд хяналт тавих, таслан зогсоох, хариуцлага тооцох эрхтэй юм. Тухайлбал, хүүхдийг хувцас, хоол, орон байраар зориуд гачигдуулсан, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хүнсний зүйл хэрэглүүлсэн, сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол иргэнийг тавин нэгжтэй тэнцэх, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Мөн хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, эрүүл мэнд, амь нас, нэр хүндэд нь харшлах тоглоом, наадамд оролцуулсан бол хувь хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох юм. Түүнчлэн сургууль, дотуур байранд сурагчийг дарамталсан, ялгаварлан гадуурхсан, бие махбодод халдсан, хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд иргэнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Цаашид улсын байцаагчдын тоог нэмэгдүүлэх, сургах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай.⁸

Хүүхдийн элч

Хүүхдийн элчийг сонгон ажиллуулах журмыг ГБХЗХГ-ыг даргын 2017 оны 06-р сарын 13-ны А/98 баталсан. Хүүхдийн элч нь 2 жил тутамд Хүүхдийн чуулганаар сонгогдох ба жил бүр хүүхдийн чуулгандаа тайлагнадаг.

⁸ *ГБХЗХГ-ын тайлан мэдээ*

Хүүхдийн Эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, 20.6, 20.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Хүүхдийн элчийг сонгон ажиллуулдаг бөгөөд Нийслэлийн 9 дүүрэгт Хүүхдийн 10 элч тангаргаа өргөн харьяа дүүргийнхээ хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох ажилтан, байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, холбогдох асуудлаар бодлого, шийдвэр гаргуулахад нөлөөлж, хүүхдийн дуу хоолой болох үүрэгтэй.

Боловсролын салбарын үүрэг оролцоо

Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжихэд боловсролын салбар чухал үүрэгтэй. ХЭТХ-ийн 6.2-д “Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ” гэж заасан.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 18.2-д “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно” гэж, 18.3-т: “Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу... зохион байгуулна” гэж заасан.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 1.2-т: “Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэх” гэж боловсролын зорилгыг тодорхойлсон.

2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.13. –д “Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлнэ” гэж заасан нь ЕБС-ийн Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болно.

Гэр бүл дэх хүүхдийн оролцоо ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож буй байдал

Гэр бүлийн тухай хуулийн 25.1-д “Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ.” гэж заасан ба тус хуулийн 14.7.-д гэрлэлт цуцлуулахад хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд, 74.5-д.асран хүмүүжүүлэхээр шилжүүлэхдээ “Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол түүний саналыг харгалзан үзнэ” гэж 55.4-д хүүхэд үрчлэхэд “долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна” гэж заасан. “Бага насны хүүхэд” гэдэгт Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.-д заасан 0-7 насны буюу иргэний эрх зүйн чадамжгүй, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-д заасан 7-14 хүртэлх насны буюу иргэний эрх зүйн зарим чадамжтай этгээдийг тус тус ойлгоно гэжээ.

Монгол улсын дээд шүүхийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмжид⁹ Хүүхдийн саналыг харгалзан үзэхдээ: а/ Хүүхдээс санал авахдаа түүний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх болон төрөл садны хүнийг байлцуулахгүй байх нь зохимжтой, б/ Хүсэл зоригоо илэрхийлэхэд хүүхдийн анхаарлыг сарниулахгүй байх, тайван, тухтай газар (өрөөг) сонгох, в/ Саналыг авахад өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, иргэдийн төлөөлөгчдийн аль нэгийг байлцуулах нь зүйтэй, г/ Хүүхдэд тавьж буй асуултыг зөв сонгох (ээждээ хайртай юу эсхүл аавдаа хайртай юу, аав, ээжийн хэнийх нь зөв бэ г.м. хариулт өгөх боломжгүй, эсхүл хүүхдийн мэдэх, ойлгох учиргүй зүйлийг асуух нь буруу) гэж тайлбар зөвлөмж өгсөн байна.

Улсын хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын байдлаар эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны нийт шүүх, шүүхийн тамгын газраас судалгааг авахад эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны 60 шүүхийн байрлах нийт 35 байрны 22 байранд нь 2007-2019 онуудад ШЕЗ, ШТГ өөрсдийн болон гаднын байгууллагын тусламж дэмжлэгээр хүүхэд, гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх өрөөг (хүүхэд, гэрч, хохирогчийг хамгаалах өрөөг давхар ашиглаж байна) гаргаж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр тохижуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

⁹ Монгол улсын дээд шүүхийн зөвлөмж. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай. 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдөр. УБ хот.

Аймаг дүүргийн хүүхдийн төлөө зөвлөл

Хүүхдийн оролцоог дэмждэг байгууллагуудын үйл ажиллагаа өргөжин 2002 онд нийслэл болон бүх аймагт Хүүхдийн төлөө зөвлөлүүд байгуулагдсан. Хүүхдийн Төлөө Үндэсний газар (ХТҮГ) нь байгууллагынхаа бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 21 аймгийн хүүхдийн төлөөллийг оролцуулан 2003 онд хамтран боловсруулсан нь өөрчлөлт, шинэчлэлтийн нэгэн илрэл болж, хүүхдийн зөвлөлүүд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын (ИТХ) дэргэд байгуулагдах эхлэлийг тавьсан юм. ХТҮГ-ын Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 197 дугаар тогтоолоор баталсан бөгөөд стратегийн үндэслэлийн тавдугаарт “шийдвэр гаргах бүх түвшинд хүүхдийн зохион байгуулалттай төлөөллийг оролцуулах боломж бүхий бүтэц бий болгож Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, ХТҮГ, орон нутгийн үйл ажиллагаанд нэвтрүүлбэл илүү их үр дүнд хүрэх болно. Энэ бүтцийг шийдвэр гаргах түвшний бүтэцтэй холбох үүргийг ХТҮГ гүйцэтгэнэ. Хүүхдийн оролцоог бүтцэд тусгах нь иргэний нийгэмд чухал үүрэг гүйцэтгэж, хүүхдийг ардчилсан нийгэмд идэвхтэй, бүтээлчээр оролцоход нь суралцуулж бэлтгэнэ...” хэмээн тэмдэглэсэн байдаг. Өнөөгийн байдлаар хүүхдийн зөвлөлүүд бүх аймгийн ХТТ-ийн дэргэд үүсгэн байгуулагдан ажиллаж байгаа хэдий ч тэдгээрийн эрхэлж байгаа ажил, үйл ажиллагааны цар хүрээ, аймгийн хүүхдийн байдалд оруулж байгаа хувь нэмэр тодорхой үр дүнтэй байж чадахгүй байна.

Хүүхдийн оролцооны чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага болон олон улсын байгууллагууд

Хүүхдийн хөгжил, оролцооны үндэсний сүлжээ

Монгол Улсад хүүхдийн оролцоог дэмжих, тэдний дуу хоолойг сонсох, тэдэнтэй хамтран ажиллах талаар нэлээд анхаарч бусад орны туршлага судлах, хэрэгжүүлэх ажлуудыг эрчимтэй явуулж ирсэн. Хүүхдийн байгууллага хөдөлгөөн, түүний мөн чанар нь үргэлж үүсгэн санаачлагч, өөрчлөн шинэчлэгч онцлогтой учраас шинэ хүсэл эрмэлзэл, шинэ арга барил, эрэл хайгуулаар арвин байдаг.

2004 онд Олон улсын хүүхдийн Найрамдал төвд болсон хүүхдийн чуулганы үеэр МУЗН-ийн Хүүхэд залуучуудын хөдөлгөөн, Монголын Скаутын холбоо, Дэлхийн Зөнгийн дэргэдэх Хүүхдийн зөн нэгдсэн зөвлөл, Залгамжлагч холбооны санаачилгаар “Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээ” төрийн чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх чиглэлээр Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран

ажиллах үйл ажиллагааны хүрээнд байгуулагдан, хүүхэд өсвөр үеийнхний нийгмийн амьдралд оролцох, хөгжих, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангахад бодитой хувь нэмэр оруулах зорилгоор ажиллаж эхэлсэн.

Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээнд доорх 16 байгууллага нэгдэн хамтран ажилладаг бөгөөд зарим байгууллагын үйл ажиллагааны талаар товч дурдвал.

- Монголын скаутын холбоо ТББ
- МУЗН-ийн хүүхэд залуучуудын хөдөлгөөн
- Монголын сурагчдын холбоо ТББ
- Ирээдүйн нээлттэй цонх ТББ
- Оюунлаг өсвөр үе (Залгамжлагч холбоо) ТББ
- Хүүхдийн танин мэдэхүйн Цох сонин ТББ
- Дүдү боловсрол сан ТББ
- Хүүхэд өсвөр үеийг ивээх төв ТББ
- Эмэгтэй скаутын холбоо ТББ
- Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ
- Хүүхэд залуучууд оролцоо хөгжил ТББ
- Хүүхэд хүүхдийн төлөө ТББ
- Нийслэлийн хүүхдийн холбоо ХӨУБ
- Хүүхэд хөгжил хамгааллын иргэншил хөдөлгөөн ТББ
- Монголын зуслангуудын холбоо ТББ
- Хүүхэд ирээдүйн баялаг ТББ

“Монголын скаутын холбоо” ТББ

Скаутын андгай хуульд тулгуурлан залуу үеийнхний боловсролд хувь нэмэр оруулж, ирээдүйн амьдралаа цогцлоон байгуулах, нийгэмд бүтээлч байр суурь эзлэх, бие даасан хувь хүмүүсийг төлөвшүүлэхэд туслах зорилгоор манай орон 1992 оны 4 дүгээр сарын 16-нд энэхүү хөдөлгөөний үзэл санаа, зорилго, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, манай орны нийслэл болон бусдад хэд хэдэн аймагт байгуулагдсан скаутын анхны бүлгүүд, тэдгээрийн дэмжигчид Улаанбаатар хотноо хуран цугларч Монголын Скаутын Холбоог зохион байгуулах Их хурлыг хуралдуулснаар анх байгуулагдсан юм.

Өнөөдөр нийслэлийн 8 дүүрэг, 19 аймаг байгаа салбар зөвлөлөөрөө дамжуулан жил бүр скаутын хөтөлбөрийг 5000 хүүхдэд шинээр, түнш байгууллагуудтай хамтран 3000 орчим хүүхдэд хүрч ажилладаг. Гишүүнчлэлийн хувьд бүртгэлтэй 13157 гишүүнтэйгээс хүүхэд 10526, насанд хүрэгчид 2631, үүний 5263 эрэгтэй, 7894 эмэгтэй, харин идэвхтэй 9215 гишүүдийн 7089 хүүхдүүд, 2126 насан хүрэгчид байдаг ба эрэгтэй 4043, эмэгтэй 5172 байна.

МУЗН-ийн “Хүүхэд залуучуудын хөдөлгөөн”

Монголын улаан загалмай нийгэмлэг нь Хүмүүнлэгийн чиглэлээр төрдөө нэмэлт хүч болж ажилладаг Үндэсний хүмүүнлэгийн байгууллага бөгөөд Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Донорын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Бид үндэсний хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг, онцгой 3 албад, нийт 34 дунд шатны хороогоор дамжуулан 75 000 гаруй хүүхэд, залуусыг Хүмүүнлэгийн эгнээнд нэгтгэж, Хүүхэд залуусын дунд хүнлэг энэрэнгүй үзлийг дэлгэрүүлэх, тэднийг Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, үе тэнгийнхэндээ эерэгээр нөлөөлөх чиглэлээр ажиллаж байна.

Өнөөдөр 19 аймаг, 8 дүүрэгт 222 Хүмүүнлэгийн танхим ажиллаж, 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд 394 Өсвөрийн улаан загалмайн бүлэг, бүлгэм, Их дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн дэргэд 15 Залуучуудын улаан загалмайн клуб ажиллаж, улсын хэмжээнд нийт 75 000 гаруй гишүүд, дэмжигчидтэй.

Хүүхдийн танин мэдэхүйн “Цох” сонин

Хүүхдийн танин мэдэхүйн “ЦОХ” сонин нь 1998 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдүгээ 22 дахь жилдээ хүүхдэд зориулсан танин мэдэхүйн мэдээ мэдээллийг түгээж байгаа үндэсний хэмжээний тэргүүлэх сонин юм. Цох сонин хүүхдэд хэрэгцээт мэдээ мэдээллийг хүргэх, амьдрах арга ухаанд сургах, тэдний авьяас билгийг хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа зорилго болгон ажилладаг.

“Цох” сонин хүүхэд хаана ч авч явахад тохиромжтой авсаархан байдлаар нь сард нэг удаа А4 хэмжээтэй сэтгүүл хэлбэрээр хэвлэгдэж, хот, хөдөөгийн 60 гаруй сургуулийн 10.000 гаруй сурагчдын гарт захиалгаар дамжин хүрч уншигддаг. “Бяцхан цох” сэтгүүлээ цэцэрлэгийн 2-3 болон 4-6 насныханд зориулан гаргаж хот хөдөөгийн 9000 орчим хүүхдэд хэрэгцээт мэдээ мэдээллийг хүргэн ажилладаг.

“Монголын сурагчдын холбоо” ТББ

Монголын Сурагчдын Холбоо нь 2004 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд сурагчдын эрх ашгийг хамгаалах, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүүхдийн дуу хоолойг нийгэмд хүргэх, биеэ даасан чадварлаг манлайлагч, өрсөлдөх чадвартай иргэнийг бий болгох зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Энэхүү зорилгынхоо хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийслэл төдийгүй хөдөө орон нутгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, багш эцэг эхчүүдэд зориулсан олон талт ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байна.

Нийслэлд ерөнхий боловсролын 197 сургууль, улсын хэмжээнд 350 сургууль дээр тогтмол хамтын ажиллагаатай үйл ажиллагаа явуулж байна. Лидер сурагч академи нь нийслэлийн 9 дүүрэг 12 аймагт салбар зөвлөлтэй, 300 гаруй үндсэн гишүүн 3000 гаруй оролцооны гишүүнтэй хүүхдийн өөрөө удирдах зөвлөл юм.

Хүүхдийн хөгжил оролцоо хамгааллын чиглэлээр “school police” эцэг эхийн эргүүл, Лидер сурагч академи, “Лидер сурагч” цогц хөтөлбөр, “өсвөрийн 333 сурагч багш” бэлтгэх үндэсний хөтөлбөр, “Хүүхэд хөгжлийн 5 хоног”-ийн цогц хөтөлбөр сургалт, “Амьдралын гараа 800 оноо” хөтөлбөр, Сурагч тэтгэлэг хөтөлбөр, “Оны тэргүүний сурагчдын харшийн сүлд модны наадам” “Оролцоод хөгжье” хөтөлбөр Соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГ-тай хамтарсан Хүүхдэд шударга байдлыг төлөвшүүлэх “Туулай хүүгийн адал явдал” хөтөлбөр, гэнэтийн осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор НГБХЗГ-тай хамтарсан “Алтан Мөнгөн шагай” хөтөлбөрүүдийг тус тус амжилттай зохион байгуулж байна.

ЕБС дээрх хүүхдийн хөгжил оролцооны чиглэлийн үйл ажиллагаа:

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилт судалгаагаар 10 хүүхдийг хөгжүүлэх, оролцуулах чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал:

Сурагчдыг төлөвшүүлэх чиглэлээр: Авьяас, харилцаа, төлөвшил, оролцоо, зөв хувцаслалт, зөв монгол хүүхэд, өсвөрийн сурвалжлагч

Байгаль орчноо хамгаалах, Өв соёлоо уламжлуулах чиглэлээр: Эко бүлэг, байгаль орчин, тэмдэглэлт баяр, талархлын өдөр, хүүхэд ба гэр бүл, уламжлалт ёс заншил

Сургуулийн үйл ажиллагаа сургалтыг дэмжих чиглэлээр: Эрүүл мэнд, ахиц амжилт, ангийн үйл ажиллагаа, сургуулийн үйл ажиллагаа

¹⁰ *Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилт судалгааны тайлан, Боловсролын хүрээлэн, 2019*

Хүүхэд хамгаалах чиглэлээр: Сонор бүлэг, аюулгүй орчин, ангийн дарга нарын холбоо, боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж

Ангийн түвшинд хийгдэж байгаа ажлуудыг ТАНИН МЭДЭХҮЙН талаас авч үзвэл:

Сурагчдын танин мэдэхүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн ажил:

АХА Эко аялал Мэтгэлцээн, Рубик шоо, Дөрвөн бэрх, Би Монгол хүүхэд, “Дэвжээ” тэмцээн,

Ээждээ захиа бичье”, Дээлтэй Монгол өдөрлөг, “Монгол бахархлын өдөр”, Сурагч миний нэрийн хуудас, Цахим гэмт хэргээс хамгаалах, “Бөмбөрцгийн залуус” тэмцээн, “Эрхэм сайн хөвгүүн” тэмцээн,

Багш нар сурагчдынхаа онцлог, сонирхол, төлөвшлийг үнэлэх чиглэлээр болон эрүүл мэндийг нь хамгаалах зорилгоор зохион байгуулдаг ажил:

Илтгэл, Судалгаа оношилгоо Витаминжуулалтын аян, Шүдний үзлэгт хамрагдах, Хувийн ариун цэврийн үзлэг, Хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгох” сэдэвт сургалт, “Ангийн цэвэрлэгээг соёл болгох” сургуулийн аянд оролцох, Мэргэжлийн сэтгэл зүйчээс анги нийтээр сургалт авах ажлуудыг зохион байгуулдаг байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Цасны баяр, “Дөл “тэмцээн, Ногоон гэрэл-Цагаан шугам, Намрын спартикат, Бие бялдрын түвшин тогтоох сорил, Сургуулийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, Дүүргийн спортын тэмцээн, Сургуулийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн, “Аврагч” онцгой байдлын тэмцээн, Цомын төлөөх Сагсан бөмбөгийн тэмцээн, Мини волейболын тэмцээнд оролцох зэрэг сурагчдад зориулсан уралдаан тэмцээнээс гадна багш, эцэг эх асран хамгаалагч болон сургуулиа төгсөгч хүүхдүүдэд зориулсан Сагсан бөмбөгийн төгсөгчдийн тэмцээн, Багш, ажилчдын эрүүл мэнд, спортын өдөрлөг, Эцэг эхийн гар бөмбөгийн тэмцээн, “School police” эцэг,эхийн эргүүлд гарах зэрэг аль болох анги нийтээр болон эцэг эхийг бүрэн хамруулан оролцуулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг байна.

Урлагийн чиглэлээр: Номын баяр, Найрал дуу, Хүрэл тулга-Уран жиргээ, Үлгэрийн баатрууд амилсан нь, Монгол гоёл-Монгол соёл, “Номын монита багш нар, Цагаан сар, Үсэглэлийн хаад, “Ээждээ захиа бичье”, Би Монгол хүүхэд- Үнсгэлжин, “Эрдмийн баяр”, “Дэвжээ” тэмцээн, Урлагийн наадам, Авьяаслаг багш, Тунгаамал” эх хэл нэвтрүүлэг, “Шилдэг хамтлаг” дууны тэмцээн, Хичээлийн шинэ жилийн нээлт, “Тавтай морилоорой” өдөрлөг, Сүлд модны наадам, Ургацын баяр, Цэцгийн баяр, Соёл хүмүүжлийн ажлын нээлт, “Бөмбөрцгийн залуус” тэмцээн, Дизайн ба загварчлал тэмцээн, Цагаан толгойн баяр, “Үндэсний өв соёл “аян, /

Монгол хувцас/ Орос дууны уралдаан, “Миний нүдээр”, Гар зургийн уралдаан, Сайн сурагч хүүхэд нэг бүрийн авьяасыг нээж хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион явуулж байна.

Хүүхдийн сонирхолтой холбоотой: Мэтгэлцээний клуб, Скаут, IQ , Эко клуб, Эмч клуб, Нөхөрсөг бүлэг, Өсвөрийн аврагч, Өсвөрийн цагдаа, Өсвөрийн сэтгүүлч, Замын хөдөлгөөн, Гар утасны хэрэглээ, Сурагчдын удирдсан СОНБ үйл ажиллагаа явуулдаг байна.

Сурагчдын оролцооны байгууллагын чиглэлээр:

СӨУ Зөвлөл, Харах чадвар, Оролцоод хөгжье 4-10, Харилцааны сургалт, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, Эцэг эхийг сонсох өдөр, Хуулиа мөрдье- бидний амьдралд, бүлгийн найзуудын цаг, хорт зуршлаас хол байя, эрүүл шүд инээмсэглэл сургалт, сэтгэл зүйчийн цаг, сурах чадварын үнэлгээ, судалгаа, эрсдэлийн үнэлгээ, мэргэжлийн судалгаа, илтгэх хуудас, тайлан бичиж үйл ажиллагаагаа тайлагнаж олон нийтэд таниулдаг байна.

Олон улсын байгууллагууд

НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС)

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Өсвөр үе хөтөлбөр сургуулийн өмнөх наснаас эхлэн өсвөр үе (амьдралын хоёр дахь арван) хүртэлх хүүхэд бүрийн эерэг, цогц хөгжлийн төлөө ажилладаг. НҮБ-ын Хүүхдийн сан дараах үйл ажиллагааны хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажилладаг. Үүнд: ялангуяа өсвөр үеийнхэнд зориулсан суралцах үйл явцын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, үндэсний болон аймаг орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнүүдийг өсвөр үеийнхэнд ээлтэй сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлд чадавхжуулах, сургуулийн нийгмийн ажилтан, эмч нарын өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд хандах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аюулгүй, эрүүл суралцах орчныг бүрдүүлэх, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, мэдлэг олгохдоо технологийн инновацийг ашиглахад хамтран ажиллаж байна.

Хүрсэн гол үр дүн: НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй сургуулиудад байгуулагдсан Хүүхэд хөгжлийн төвүүдийг түшиглэн Засгийн газраас сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагаанд баримтлах бодлогын баримт бичгийг батлан, багш нарт зориулсан аргачлалыг боловсруулсан. НҮБ-ын Хүүхдийн сан өсвөр үеийнхний хувь хүний болон нийгмийн хөгжилд тустай чадвар бий болгох үүднээс амьдрах арга ухаан,

үе тэнгийнхний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. НҮБ-ын Хүүхдийн сан залуучуудын эрх мэдэл, оролцоог хангах үүднээс мэдээллийн технологид суурилсан шийдлүүд бүхий “Инновацийн сорилт”-ыг зохион байгуулсан. Энэ хүрээнд өсвөр үеийнхэн болон залуучуудад зориулсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар гар утасны тоглоомын аппликейшн боловсруулж байна.¹¹

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар (ЯХИС)

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөр НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенцоор баталгаажсан хүүхдийн салшгүй бүх эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тогтолцоог дэмжихүйц хүүхдийн төлөө сайн засаглалыг бий болгохын тулд эрх эдлэгч болон иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажилладаг. Тус хөтөлбөр нь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээнд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн болон үндэсний түвшинд хүүхдүүдийн нөлөөлөл, дуу хоолойг дэмжих, олон нийт иргэний нийгмийн байгууллага, хүүхдүүдийг хүүхдийн эрхийн зөрчилд мэдрэг нээлттэй, хариуцлага шаарддаг болгон чадавхжуулах, хүүхдэд зориулсан суурь үйлчилгээнд зарцуулах улсын болон орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулах асуудалд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хүүхдийн утга төгөлдөр оролцоо, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг илтгэсэн судалгааны ажил зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна.¹²

Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллага (ДЗОУБ)

Дэлхийн Зөн Монгол ОУБ нь хүүхдэд чиглэсэн, хүмүүнлэгийн байгууллага бөгөөд Монгол Улсад 1993 он байгуулагдсан цагаасаа эхлэн орон нутгийн хөгжлийг дэмжих, эерэг өөрчлөлтийг бий болгох зорилгоор өөрийн урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Урт хугацааны хөтөлбөрүүд дотор Дэлхийн Зөн Олон улс даяар хэрэгжүүлдэг Орон нутгийн оролцоо ба Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр, Хүүхэд Хамгаалал, Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөр, Яаралтай тусламж, Ус, Орчны эрүүл ахуй зэрэг хөтөлбөрүүд багтдаг. Өнөөдөр Дэлхийн Зөн Монгол ОУБ нийт 16 аймаг, 8 дүүрэгт өөрийн Орон Нутгийн Хөтөлбөрүүд болон богино хугацааны хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан хүрч ажиллаж байна.

¹¹ <https://www.unicef.org/mongolia/mn>

¹² Бүхнийг хүүхдийн төлөө, Хүүхдийг Ивээх Сан Монгол. 2017

Хүүхдийн утга учиртай оролцоог дэмжих чиглэлээр ДЗМОУБ нь: Өсвөр насны хүүхдийн амьдрах ухааны “Оролцоод хөгжье” клубийн аргачлалаар 16 аймаг 8 дүүргийн зорилтот сургуулиуд дээр “Оролцоод Хөгжье” 483 хүүхдийн клубээр дамжуулан нийт 10800 хүүхдүүдэд, гамшгийн эрсдэлийг даван туулах, яаралтай тусламжийн чиглэлээр Онцгой байдлын Ерөнхий Газартай хамтарсан “Өсвөрийн Аврагч” клуб улс орон даяар 296 сургуулийн 321 “Өсвөрийн Аврагч” Клуб-р 8000 гаран хүүхэд хичээллэж байна. Сурагчдын өөрөө удирдах зөвлөл “Сэтгүүлч” клуб ХОУЗ буюу “Хүүхдийн оролцооны удирдах зөвлөл” 408 клубийн хүүхдүүдийг чадавхжуулах сургалт хөтөлбөрүүд болон хүүхдийн санаачилсан төслийг санхүүжүүлэн дэмжиж байна.

III БҮЛЭГ. ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар хийсэн судалгаа төдийлөн олон биш байна. Тайлангийн энэ хэсэгт энэ чиглэлээр өмнө хийгдсэн зарим судалгааг тоймлолоо.

- Засаглал дахь хүүхдийн оролцооны өнөөгийн байдал судалгаа нийслэлийн түвшинд хийгдсэн бөгөөд уг судалгаагаар сургууль дахь хүүхдийн оролцооны түвшнийг үнэлэхэд 51.7% нь оролцоо муу, төсөвлөлтөд хүүхдийг оролцуулдаггүй гэж 72.7 % хариулсан. (IRIM Mongolia, ЯХИС, 2013 он)
- “Өсвөр үеийнхний дуу хоолой-1” 2017 судалгаа,. Энэхүү судалгаанд Улаанбаатар хотын есөн дүүргийн ерөнхий боловсролын 14 сургууль, түүний дотор тусгай хэрэгцээтэй хүүхдүүд суралцдаг хоёр сургуулийн 6, 8, 10-р ангийн 1236 сурагч хамрагдсан. Судалгаанд оролцсон 3 хүүхэд тутмын 1 нь сургуультай холбоотой асуудлаар дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй байсан бөгөөд 53.4 хувь нь сургуулийн орчинд дарамт хүчирхийлэлд өртсөн гэсэн дүн гарсан. Хүүхэд өөрсдөө хамааралтай аливаа шийдвэрт санал бодол дуу хоолойгоо хүргэх боломж бодит байдал хомс байна гэж 87,4 % үзсэн. Мөн өөрт чухал асуудлаар санал бодлоо илэрхийлж чадсан гэж хариулсан хүүхдүүдийн 44.9% нь гэртээ, 31.9% нь сургууль дээрээ, 13.1% нь чөлөөт цагийн арга хэмжээний үеэр 7.5% нь бусад, 2.6% нь хотын захиргаанд гэжээ. (ЯХИС, 2017 он)
- “Өсвөр үеийн дуу хоолой -2” 2018, судалгаа. Энэхүү судалгаанд хүүхдүүд сурах эрхээ хэрхэн эдэлж, эрхийг нь хэрхэн хүндэтгэж хэрэгжүүлж байгаа талаарх тэдний сэтгэгдлийг мөн тэдний сурах эрхээ эдлэхэд саад учруулж байгаа асуудлаар судалсан. Судалгаагаар боловсролын байгууллагад гардаг авилгын талаар хүүхдүүдийн 33.4% нь мэдээлнэ гэсэн бол 31.4% нь бүх тохиолдлыг бол мэдээлэхгүй тухайн нөхцөл байдлаас шалтгаална гэсэн бол 18.3% нь мэдээллээ гээд ямар ч нэмэргүй, 9.9% намайг хамгаалахгүй учраас би мэдээлэхээс айж байна. 8.9% өөртөө анхаарал татмааргүй байгаа тул хэнд ч мэдээлэхийг хүсэхгүй

байна. 14.0% нь хаашаа хэрхэн мэдээлэхээ мэдэхгүй байна гэж хариулсан. (ЯХИС, 2018 он)

- ЕБС-ийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын 6 сургуулийн ХГҮА-ны төлөвлөлтийг сургуулийн хэмжээнд төлөвлөгдсөн ажлын 47 хувь нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хамгаалах, 17.6 хувь нь эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр, 35.2 хувь сургуулийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр болон сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлэх, зөвлөн туслах чиглэлээр тусгагдсан байна.
- Ангийн хэмжээнд хэрэгжүүлэх ХГҮА-ны төлөвлөлт нь сурагчдын төлөвшүүлэх, байгаль орчин өв уламжлалаа хамгаалдаг хайралдаг болгох чиглэлээр, сургалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр, хүүхэд хамгаалах чиглэлээр тус тус төлөвлөгдсөн байдаг байна.

Нийгэмшлийн чиглэлээр сурагчид мэтгэлцээн, илтгэх урлаг харилцаа, сайн үйлсийн аян, улаан загалмай хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гадаад хэлээ сайжруулах, хүүхдийн эрх оролцоог сайжруулах ажлуудыг зохион байгуулах сонирхолтой байна.

Сурагчдын 24.2 хувь нь мэтгэлцээн урлаг, харилцааны чиглэлээр, 40.5 хувь нь сайн үйлсийн аян, олон нийтийн ажил, улаан загалмайн чиглэлээр, 8.1 хувь нь мэргэжил сурталчлах чиглэлээр, 10.8 хувь нь сурагч солилцоо туршлага солилцох талаар, 9.9 хувь нь хүүхдийн эрх хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.

Багш нарын үзэж байгаагаар ХГҮА-г сонирхолтой хэлбэрээр хийгддэггүй “Сурагчдын зөвлөл”, “СӨУБ”-д хүүхдийн оролцоо сайн байдаг тул түүгээр дамжуулан хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр санаачилгатай ажиллах хэрэгтэй гэсэн санал дэвшүүлжээ. (БХАН, 2018 он)

Олон улсын хэмжээнд Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн байгууллагууд нь хүүхдийн оролцох эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг манлайлж ирсэн ба 2007 онд Шведийн Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн оролцооны хэрэгжилтийн нөхцөл байдал, аргачлалыг судалж зөвлөмж боловсруулсан. Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл 2015 онд Хүүхдийн оролцооны зураглал, нөхцөл байдлын судалгааг дахин хийсэн. Энэхүү судалгааны зөвлөмж үр дүнгүүд хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд чухал санаа, олон улсад байгаа нийтлэг асуудлыг зураглаж байгаа тул энэ хэсэгт дэлгэрэнгүй

орууллаа. Тус судалгаа 2015 оны 4-9 сард 18 улсад хийгдсэн бөгөөд дараах чиглэлээр хүүхдийн оролцоо 2007 онтой харьцуулахад ахиц гарсан гэж дүгнэсэн байна. Үүнд: Хүүхдийн эрхийн хяналт шинжилгээ, тайлагнах үйл явц; Хүүхдийн оролцоотой судалгааны ажил; Нутгийн удирдлага, засаглал, тухайлбал төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явц; мөн сургуулийн засаглал; Суралцах орчны чанарын үнэлгээ хийх; Хүүхэд хамгааллын олон нийтэд суурилсан механизм; Хэвлэл мэдээлэл, түүний дотор нийгмийн сүлжээ, анимал ашиглах; “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим”-ын дагуу бизнесийн салбарын оролцоог хангах; Гамшгийн эрсэдлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах; Онцгой байдлын хариу арга хэмжээ; Хяналт шинжилгээ, үнэлгээ, хариуцлагатай байдал ба суралцах (MEAL) зэрэг чиглэлээр хүүхдийн оролцоог дэмжих дэмжлэг нэмэгдсэн байна гэжээ. Дээрх судалгаагаар 2007 оны судалгаанаас хойш дараах чиглэлээр хүүхдийн оролцоог дэмжих дэмжлэг сул байгаа тул ахиц гараагүй байна гэж дүгнэсэн. Үүнд: Хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах; Хүүхдийн санал хүсэлтийг сонсох, тэдний өмнө хариуцлага хүлээх; Эрүүл мэнд, хоол тэжээлийн хөтөлбөрүүд; Гэр бүл дэх оролцоо; бага насны хүүхдүүдийн оролцоог дэмжих (10-аас доош насны) чиглэлээр ахиц гараагүй гэжээ. Мөн дараах чиглэлд хангалттай хүчин чармайлт гаргахгүй байна гэж үзсэн. Үүнд: Төслийн санал боловсруулах болон сэдэвчилсэн хөтөлбөрүүдэд хүүхдийн оролцоог хангах төлөвлөгөө, төсөв, хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтийг тусгах; Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудын сүлжээг янз бүрийн түвшинд (орон нутгийн түвшнээс эхлээд дэлхийн хэмжээнд) дэмжих; Хүний нөөцийн бодлогод ажлын байрны тодорхойлолт, ажилтнууд, түншлэгчдийг ажлын байранд танилцуулах, сургах, удирдлагын зүгээс ажлыг нь дүгнэх зэрэгт хүүхдийн оролцоог багтаах; Хүүхдийн оролцооны туршлагыг системтэйгээр баримтжуулах, үнэлэх, суралцах, солилцох; Хүүхдийн оролцооны талаар шинэ болон одоо байгаа удирдамжуудыг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх зэрэг дутагдалтай байна гэж үзсэн.

Дээрх судалгаагаар нийт 17 зөвлөмж өгсний 12 нь ХИС-ийн дотоод, үлдсэн 5 нь гадагшаа чиглэсэн зөвлөмжүүд байсан. Сүүлийн 5 зөвлөмжид:

- Насанд хүрэгчид (эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтнууд, төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт) –ийн мэдлэг, мэдээлэлийг дээшлүүлэх, гэр бүл, сургууль, олон нийт, хот болон үндэсний, бүс нутгийн, дэлхийн хэмжээнд шийдвэр гаргах үйл явцад охид хөвгүүдийн оролцоог дэмжиж буй

- одоо байгаа эерэг хандлага, уламжлалыг олж тогтоох, тэдгээрт суурилах, сөрөг хандлагыг өөрчлөх,
- Хүүхдийн оролцоо, иргэний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаа, механизмыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг төлөвлөх, төсөвлөх, хяналт шинжилгээ хийхэд нь орон нутгийн болон үндэсний засаг захиргааны байгууллагууд, оролцогч талуудад сурталчлан таниулах, түншлэлийн харилцааг нэмэгдүүлэх.
 - Үндэсний, орон нутгийн засаглал, сургуулийн засаглал дахь хүүхдийн оролцоог хангах, мөн хүүхдийн удирдлагын байгууллагуудыг бүртгэх боломжийг олгохуйц хууль эрх зүйн болон бодлогын өөрчлөлтийг сурталчлах,
 - Сургуулийн удирдлага, орон нутгийн засаг захиргаа, үндэсний засаглал дахь хүүхдийн оролцоог институтчилэх чиглэлээр төр засаг, сургуулийн удирдлагуудад сурталчлан таниулах ажлын хүрээнд хүүхдийн байгууллагууд, эвсэл, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх,
 - Хүүхдийн амьдралд нөлөөлөхүйц хууль, бодлого, үйл ажиллагаа, төсөв, асуудлын талаар хүүхдэд ээлтэй мэдээлэл боловсруулах, түгээхийг сурталчлах; насны болон чадварын хувьд ялгаатай охид, хөвгүүдэд өөр өөр нөхцөл байдалд үзэл бодлоо илэрхийлэх, тэдэнд хамааралтай шийдвэр гаргахад оролцуулах хүүхдэд ээлтэй арга хэрэгслийг боловсруулах, түгээхийг дэмжин сурталчлах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн.

3.2. НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ТАЙЛАН ИЛТГЭЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улс Хүүхдийн эрхийн хороонд илгээсэн НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тайлан илтгэлүүдэд хүүхдийн оролцох эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тайлагнасан байдал болон Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжүүдийг нэгтгэлээ. Монгол улс Засгийн газар 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсноос хойш 1, 2, 3-4, 5-р тайлан илтгэлүүдийг өгч зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна. Эдгээр тайлан болон зөвлөмжөөс Монгол Улсад хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилт төдийлөн сайн хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

1. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар тайлан илтгэл /1994 он/

Тайланд:

- Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаарх эцэг эхийн үүрэг ролийн чухлыг анхаарч Монголын радио эцэг эхчүүдэд зориулсан “Эцэг эхийн боловсрол” зэрэг хэд хэдэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлсэн.
- 12-р зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд 30 –аад үйл ажиллагаа түүний дотор уралдаан, хурал, уулзалт ярилцлага, телевиз, радиогийн нэвтрүүлэг, Хүүхдийн утас, Улаан шугам, Хүүхдийн үг зэрэг үйл ажиллагааг уламжлал болон хөгжсөн.
- Хүүхдэд зориулсан ном хэвлэл, номын сан, хүүхдийн зохиолчдын уран бүтээлийг дэмждэг.
- Монгол Улсад хүүхэд бүр хүссэн мэдээллээ хайх эрхтэй. Сүүлийн жилүүдэд хүүхдэд зориулсан мэдээллийн хэмжээ, агуулга, эх сурвалж ихэссэнтэй холбоотойгоор садар самуун, хэрцгий кино аюултай мэдээллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлага бий болж байна.
- Сургууль завсардалтын тоо нэмэгдэж тэдгээр хүүхдийн мэдээлэл олж авах нь хязгаарлагдмал, өөрсдийгөө илэрхийлэх боломж хомс байна.
- Монгол Улсад хүүхдийн сайн дурын 6 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: 8000 гишүүнтэй Сүхбаатарын нэрэмжит Монголын хүүхдийн байгууллага, Монголын өсвөр үеийнхний хөдөлгөөн (албан ёсны гишүүнчлэлгүй хөдөлгөөн), 5000 гишүүнтэй Монголын Скаутын Холбоо, 900 гишүүнтэй Залуу техникчдийн холбоо, Эх дэлхий холбоо (гишүүнчлэлгүй), 500 гишүүнтэй Гадаад хэл сонирхогчдын холбоо орно. Хөдөө орон нутагт хүүхдийн хоолой, үзэл бодлыг илэрхийлэх боломжийг хангах хүүхдийн холбоо нийгэмлэг үйл ажиллагаа явуулдаг.

Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад тулгарч буй бэрхшээл:

- Эцэг эх, багш, хүүхдийн асуудлаар мэргэшсэн хуульч, социологич бусад мэргэшсэн хүмүүсийг хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар сургах сургалтын хөтөлбөр байхгүй байна.
- Хүүхдийн асуудлыг зохицуулж буй ихэнх журмууд өөрчлөгдөж буй нөхцөл байдалд нийцэхгүй байна.
- Санхүүгийн бэрхшээлтэй холбоотойгоор хүүхдийн ном хэвлэл, радио телевизийн нэвтрүүлгүүд насаар ангилагдах боломжгүй

- болж тоо нь буурч, хүүхдийн мэдээлэл олж авах боломж хомс болсон.
- Засгийн газраас хүүхдийн байгууллагуудад санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх тодорхой тогтолцоо байхгүй.

Шаардлагатай арга хэмжээ:

- Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар эцэг эх, багш, хуульч бусад мэргэжлийн хүмүүсийг сургах, ур чадварыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
- Хэвлэл мэдээллээр дамжуулан хүүдийн үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дээшлүүлэх;
- Хүүхдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжид хүүхдийн энэ эрхийг хуульчлан баталгаажуулах;
- Мэдээлэл хүлээн авах боломжгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах арга хэмжээ авах;
- Төрийн бус байгууллага болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн хуулийн төслүүдэд хүүхдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж тусгах;
- Хүүхдийн байгууллагуудад Засгийн газрын дэмжлэг дор үйл ажиллагаа явуулах боломж олгох тогтолцоо бий болгох.

Зөвлөмжид:

- Хүүхдийн төлөө Үндэсний төв, хүүхдийн асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл зэрэг хүүхдийн аж байдал, эрхийн асуудлыг зохицуулах механизмууд бий болгосныг сайшаагаад;
- 12-р зүйл дэх хүүхдийн санаа бодлыг хүндэтгэх тухай зарчмыг улсынхаа хууль тогтоомжид бүрэн тусгаагүй байгаад Хороо эмзэглэж;
- Энэ асуудлыг үндэсний хууль тогтоомжид тусгах, олон түмний мэдлэг мэдрэмжийг дээшлүүлэх;
- Хүүхэдтэй тулж ажилладаг буюу хүүхдийн төлөө ажилладаг мэргэжлийн хүмүүс, багш, хууль хамгаалах байгууллагын ажилтан, нийгмийн асуудал эрхэлсэн захиргааны ажилтан, шүүгч нарт зориулж хүүхдийн эрхийн тухай сургалт зохион байгуулж явуулах хийгээд тэдгээрийн сургалтын хөтөлбөрт эл сэдвийг тусгаж оруулах.

2. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит хоёр дах тайлан илтгэл /2003 он/

Тайланд:

- Тайлант хугацаанд хүүхдийн өөрийн удирдлагын болон иргэний нийгмийн байгууллагууд олноор байгуулагдаж тэдгээр хүүхэд залуучууд хамрагдаж энэ нь тэдний үзэл бодол, санал хүсэлтээ илэрхийлэх индэр болж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байна. Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 онд батлагдсан нь иргэний нийгмийн байгууллагыг дэмжих үндсэн нөхцөл болсон.
- Хүүхэд өсвөр үеийнхний дунд төрөл бүрийн чуулга уулзалт хурлыг зохион байгуулсан. Тухайлбал “Нэг ертөнц”, “Хүүхдийн эрх”, “Хүний эрх”, “Нийгмийн хөгжил” зэрэг цуврал бага хурлууд, хүүхдийн үзэл бодлыг шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор “Бага парламент”, “Бага Засгийн газар” хуралдааныг зохион байгуулж хүүхдүүдийн саналаар 2000 оныг “Хүүхдийн жил” болгон зарласан.
- Эрх нь зөрчигдөж байгаа хүүхдийн санал гомдлыг хүлээн авах “Хүүхдийн утас”, “Хүүхдийн шуудан ажиллуулж байна.
- Хүүхдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж олгох зорилгоор хүүхдийн нэвтрүүлгийн тоо, цагийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлэв. 12 аймагт хүүхдэд зориулсан сонин гаргаж байна.

Зөвлөмжид:

- Монголын өсвөр үеийнхний эрхийг хамгаалахын тулд “Нэг ертөнц” цуврал бага хурал, мини парламентын хуралдаан, үндэсний чуулга уулзалтууд зохион байгуулах зэргээр өөрсдийн эрх ашигтай холбоотой бүхий асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн амьдралд оролцох хүүхдийн эрхийг хүндэтгэх, дээшлүүлэх талаар явуулсан Монгол Улсын үйл ажиллагааг Хороо сайшаан тэмдэглэж байна. Гэвч уламжлалт хандлагаас болоод гэр бүл, сургууль, орон нутгийн хэмжээнд хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хязгаарлагдаж байгаад Хороо сэтгэл зовниж байна.
- Конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу бүх хүүхдийн ялангуяа охидын санаа бодлыг хүндэтгэн үзэх, сургууль, гэр бүл болон бусад байгууллагын өөртэй нь холбоотой бүхий л асуудалд хүүхдийн оролцоог дэмжих хүчин чармайлтаа улам бэхжүүлэхийг Хороо оролцогч улсад зөвлөж байна.
- Мөн бодлого боловсруулах, шүүхийн шийдвэр гаргах, хөтөлбөр

хэрэгжүүлэх зэрэгт хүүхдийн үзэл бодлыг хэрхэн анхааран үзэж байгаа, энэ нь дээрх үйл явц болон хүүхдүүдэд ямар үр нөлөөтэй байгааг байнга үнэлж үзэж байхыг оролцогч улсад зөвлөж байна.

3. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит гурав, дөрөвдүгээр тайлан илтгэл /2007/

Тайланд:

- Хүний эрхийн Үндэсний комисс, Хүүхдийн төлөө үндэсний газар хамтран “Хүүхдийн элчийг шалгаруулах журам”-ыг боловсруулан гаргаж, аймаг, нийслэл, сумын түвшинд хүүхдийн элчээр 150 хүнийг сонгон шалгаруулах замаар ажиллуулж байна.
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд чөлөөтэй бодож, сэтгэх, мэдээлэл хайх, хүлээн авах, болон сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байна.
- Боловсролын тухай хуульд суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, түүнчлэн сургууль, цэцэрлэгийн зөвлөлд эцэг эх, сурагч, сургуулийн захиргааны төлөөллийг оруулж байхаар хуульчилсан.
- Тайлант 2004-2006 оны хугацаанд гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх, хүүхэд өөрийн эрх ашигтай холбоотой асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх байдлыг хүлээн авах олон нийтийн хандлага өөрчлөгдөж байна.
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхдийн төлөөлөл оруулах, хүүхдийн оролцоо бүхий хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах зэргээр хүүхэд, өсвөр үеийнхний дуу хоолойг бодитой дэмжиж байна. Түүнчлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж нээлттэй болсоор байна. Тухайлбал, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн сурагчдын сургуулийн удирдлагаас сурах эрхээ хүндэтгэхийг шаардсан үйл явцыг дурдаж болно.

Шаардлагатай арга хэмжээ:

- Хүүхдийн санал бодлыг хүлээн авах, шийдвэрлэх, түүний дагуу арга хэмжээ авах, үр дүнг хүүхдэд тайлагнах тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.
- Сургуулийн насны болон өсвөр насны хүүхдүүд цуглах, чуулах боломж бүхий чөлөөт цаг, хөгжлийн байр, газрыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмжид:

- Гишүүн улс холбогдох хууль тогтоомжид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг оруулж өгсөн явдлыг Хороо сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ бодит байдал дээр энэ зарчим хэрэгжихгүй байгаад харамсаж байна. Мөн түүнчлэн Хүүхдийн оролцооны үндэсний хөтөлбөрийн (2005) төслийг УИХ-аас одоо болтол батлаагүй явдалд харамсаж байна.
- Гишүүн улсын 2-р тайлангийн дүгнэлт зөвлөмжид өгч байсны нэгэн адилаар гэр бүл, сургууль, орон нутаг, халамж асрамжийн байгууллага, шүүхийн болон захиргааны шийдвэр зэрэг хүүхдэд нөлөөлж буй бүх асуудалд хүүхдийн оролцоог дэмжиж, цаашид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг сахин хэрэгжүүлж дэмжих тал дээр хүчин чармайлт гаргахыг Гишүүн улсад зөвлөж байна. Хүүхдийн оролцооны талаар үндэсний бодлогын төслийг УИХ-аас батлах ингэхдээ Конвенцийн 12-р зүйл болон хүүхдийн үг хэлэх эрхийн тухай Хорооноос гаргасан 12-р ерөнхий тайлбарыг (2009) харгалзан үзэхийг зөвлөж байна.

5. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тав дах тайлан илтгэл /2016/

Тайланд:

- Хүүхдийг өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцэхэд шууд, эсвэл хуульд заасны дагуу төлөөлөгч, зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгосон.
- Эрхэлсэн сайдын тушаалаар баталсан “ Хүүхдийн оролцоог дэмжих стратеги” –д хүүхдийг сонсох, механизмыг хууль, тогтоомж, дүрэм, журамд тусгах, хүүхдэд үзэл бодлоо болон өөрийгөө илэрхийлэн ойлгуулах чадварыг хөгжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд хүүхэдтэй холбоотой асуудал хэлэлцэхдээ хүүхдийн санал бодлыг сонсох, шийдвэртээ тусгах, хүүхдийн санал бодлыг хэрхэн тусгасан талаар эргэн мэдээлэх, мөн хүүхдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, хариу өгөх тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааг тусгасан.
- Стратегийн дагуу аймаг, дүүрэг, нийслэлд хүүхдийн чуулган жил бүр болж, хүүхдүүд, хүүхдийн төлөөлөл хамтран ярилцах, тулгамдсан асуудал, дуу хоолой, санал хүсэлтээ шийдвэр гаргагч нарт сонсгодог хэлбэр нэгэнт тогтоод байна. Тайлангийн

хугацаанд орон нутаг, үндэсний хэмжээнд жил бүр хүүхдийн чуулганыг зохион байгуулж, мөн хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхэлдэг, хурдан морь унадаг хүүхдийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулан, хэлэлцэж тэнд хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэн, өөрсдийгөө сонсгох, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэх, түүнийг нь шийдвэрлэх хүсэл зориг гаргах зэрэг үйл ажиллагааг явуулдаг хэлбэр орон нутагт түгээмэл байна.

Мөн 2015 онд ХЭК-ийн хэрэгжилтийн сүүдэр илтгэлийг ТББ-ууд бэлтгэн хүргүүлсэн. Тус сүүдэр илтгэлд:

- “Монгол улсын Засгийн газраас Хүүхдийн оролцоог дэмжих стратегийг 2011 онд баталсан боловч өнөөг хүртэл төсөв хуваарилаагүй байгаа тул хэрэгжихгүй байна. Хүүхдийн асуудал хариуцсан албан тушаалтан нь улс төрийн томилгоогоор томилогдсоноор тухайн байгууллагын ой санамж үгүй болж, хүний нөөц нь хүүхдийн эрхийн талаарх мэдлэг, мэргэжлийн ур чадвар хуримтлуулж чадахгүй байгаа нь хүүхдийн оролцох эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл болж байна.
- Хүүхдийн оролцооны ТББ-ууд оролцоог бий болгоход олон талт сайн туршлагыг бий болгож ажиллаж байна. Гэвч өнөөдөр хүүхдийн оролцооны талаар холбогдох төрийн байгууллагууд нэгдсэн ойлголтгүйгээс төрийн бодлого шийдвэрүүддээ хүүхдийн дуу хоолойг тусгахгүй байгаа хэвээр байна” гэж дүгнэжээ.
- Цаашлаад тус илтгэлд “сургуулийн түвшинд хүүхдийг сурагчдын өөрөө удирдах байгууллагаар дамжуулан оролцуулахад ашиглах хамгийн түгээмэл арга нь ангийн дарга нарын хурал, өдөрлөг, зөвлөгөөн гэх мэт байдаг. Гэтэл эдгээр үйл ажиллагаанд хамгийн идэвхтэй, онц сурдаг, ангийн дарга гэсэн цөөн тооны хүүхдүүдийг хамруулдаг бөгөөд ихэнх хүүхэд оролцож чаддаггүй. Үүнээс гадна сургуулийн дүрэм, журам, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт болон төсөвт сурагчдын оролцоог хангах үйл ажиллагаа тусгагддаггүй байна. Мөн ихэнх багш, нийгмийн ажилтнуудын оролцооны талаарх мэдлэг дутмаг, арга барилд суралцаагүй байна. Иймээс сургуулиуд хүүхдийн оролцох болон өөрийгөө илэрхийлэх чадавхыг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.” гэжээ.
- Орон нутгийн түвшний оролцооны талаар дурдахдаа “Хорооны түвшний хүүхдийн оролцоо нь тэмцээн уралдаан, хүүхдийн баярт оролцуулах гэсэн арга хэмжээгээр хязгаарлагдаж, хорооны ажилтнуудын хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт, мэдлэг

дутмаг байдаг. Нийслэлийн хэмжээний төлөвлөлтийн баримт бичгүүдэд хүүхдийн оролцоо хангадаггүй хэвээр байна. Эдгээрийг нэг удаагийн арга хэмжээ болох хурал, зөвлөгөөн, соёл урлагийн арга хэмжээ эзэлж байгаа ба өмнө нь хийгдсэн судалгаанууд болон бидний зохион байгуулсан хэлэлцүүлэг зэргээс үзэхэд шийдвэр гаргах түвшин дэх хүүхдийн оролцоо огт хангадаагүй гэж үзэж байна. Тухайлбал, аймаг, нийслэлийн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, Хүүхдийн төлөө зөвлөлд 1-2 хүүхдийг хүүхдүүдийн төлөөлөл болгон бэлгэдэл төдий оролцуулдаг хэвээр байна. Зөвлөлийн хурлаар ямар асуудал хэлэлцэх гэж байгааг хүүхдийн төлөөлөлд урьдчилан мэдээлж, бусад хүүхдүүдтэй ярилцаж асуудал дэвшүүлэх боломжийг олгохгүй байна.” гэж дүгнэжээ.

Зөвлөмжид:

- Хүүхдийн оролцоог дэмжих стратеги болон Хүүхэд хамгааллын хуульд тусгагдсан хүүхэд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжийг олгох, үзэл бодлыг нь тэдэнд нөлөөлж буй асуудлыг шийдэх явцад харгалзан үзэх заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангах;
- Нийгмийн ажилтнууд болон шүүх хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг мөрдөх тогтолцоог бүрдүүлэх замаар шүүн таслах үйл ажиллагаанд хүүхдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрхээ эдлэх боломжийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;
- Бүх хүүхдүүд, ялангуяа охид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон ЛГБТ хүүхдүүдийн дунд гэр бүл, орон нутаг, сургуулийнхаа үйл ажиллагаанд утга учиртай оролцох замаар чадваржих боломжийг нь өгч чадах хөтөлбөр, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах шаардлагатайг зөвлөсөн байна.

3.3. ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

Хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдал, хүүхдүүд болон насанд хүрэгчдийн хүүхдийн оролцооны талаарх ойлголт, байр суурийг тодорхойлох, оролцоонд тулгамдаж буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга замыг тогтоох зорилгоор 2018-2019 онд 2 удаа анкетын болон ярилцлагын аргаар судалгаа авч нэгтгэн дүгнэсэн.

Хүүхдийн хөгжил, оролцооны зураглал гаргах судалгаанд оролцогчдын үндсэн мэдээлэл

График 3.1 Судалгаанд оролцогчдын нас /Насанд хүрэгчид/




График 3.2 Судалгаанд оролцогчдын хүйс /Насанд хүрэгчид/






График 3.3 Хүүхдүүдийн нас хүйс /2019 он/



Хүйс



2018 оны 06 сар болон 2019 оны 11 сард явуулсан судалгаанд 21 аймаг, 9-н дүүргийн хүүхдийн оролцооны байгууллагын болон бусад хүүхдүүдийн төлөөлөл 1100 орчим хүүхдүүд, 13 аймаг, 5-н дүүргийн 100 насанд хүрэгчид хамрагдсан.

Судалгааны үр дүнг нэгтгэн гаргахдаа дараах бүтэц агуулгын хүрээнд дүгнэлт гаргасан. Үүнд:

1. Хүүхдийн оролцооны талаарх ойлголт
2. Хүүхдийн оролцооны хэлбэрүүд

3. Орон нутгийн байгууллагын хүүхдийн оролцооны үнэлгээ
4. Хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудал
5. Цаашид анхаарах асуудлууд

1. Хүүхдийн оролцооны талаарх ойлголт

Хүснэгт 3.1 Хүүхдийн оролцооны талаар хүүхдүүд болон насанд хүрэгчдийн ойлголт

№	Хүүхдийн оролцоо гэдэг нь	Хүүхдүүд		Насанд хүрэгчид	
		Давтамж	Эзлэх хувь	Давтамж	Эзлэх хувь
1	Өөрт хамааралтай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, өөрсдөд нь нөлөөлөх аливаа шийдвэр гаргахад оролцох	95	19,1%	25	25%
2	Оролцоо гэдэг нь зөвлөлдөх хамтдаа шийдвэр гаргах, өөрсдөө санаачлах, зорилгоо хамтдаа тодорхойлох, үр шимийг нь хүртэх гэсэн олон утгыг илэрхийлдэг	211	42,5%	45	45%
3	Хүүхэдтэй холбоотой хөтөлбөр үйл ажиллагааны бүх үе шатанд оролцох	88	17,7%	16	16%
4	Дээрх бүгд	72	14,5%	40	40%
5	Энэ талаар сайн мэдэхгүй	22	4,4%	1	1%
6	Бусад	9	1,8	1	1%
	Нийт	497	100%	100	100%

Судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн оролцооны талаарх ойлголт насанд хүрэгчид болон хүүхдүүдийн хувьд ойролцоо гарсан байгаа нь нэг талаас оролцооны талаарх ойлголт харьцангуй тогтвортой хэвшиж байгаа, нөгөө талаас хүмүүс мэддэг болжээ гэдэг нь харагдаж байна.

Оролцооны ерөнхий утга нь өөрсдийн санаачилга, хамтын төлөвлөлт, шийдвэр болон асуудлын талаар зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, түүнийхээ үр шимийг хүртэх зэргээр тодорхойлогддог бөгөөд үүнийг хүүхдийн оролцооны зөв тодорхойлолт юм гэж судалгаанд оролцогч хүүхдүүдийн 42,5%, насанд хүрэгчдийн 45% үзсэн байна.

Судалгааны хүрээнд насанд хүрэгчдээс авсан фокус бүлгийн ярилцлагаар “Та хүүхдийн оролцоо гэдгийг юу гэж ойлгож байна вэ?” гэсэн асуултад ярилцлагад оролцогчид хүүхдийг өөрт хамаатай асуудлаар шийдвэр гаргахад дуу хоолойгоо хүргэх, тэдний үзэл бодлыг хүндэтгэх, аливаа үйл ажиллагаанд нас сэтгэхүйн онцлогт тааруулан оролцуулах, нийгэмд өөрийгөө хөгжүүлж, бие дааж сурахад чухал ач холбогдолтой гэж хариулсан хариулт хамгийн өндөр давтамжтай байсан.

“Харин та хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэж тэднийг сонсдог уу?” гэсэн асуултад тэднийг сонсдог, ойлгодог, хамтран ажиллахыг хичээдэг гэж хүүхдийн байгууллагын ажилтнууд голдуу хариулж хүүхдээ хүндэтгэж сонсох нь эцэг эхийн үүрэг, хүүхэдтэйгээ найз шигээ харьцаж сонсдог гэж эцэг эхийн төлөөлөл хариулсан.

Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөнд оролцсон Нийслэлийн СБД 2-р сургуулийн сурагч:

“Хүүхдийн оролцоо гэдэг нь хүүхдүүд бид өөрстэйгөө хамааралтай бүхий л асуудлаар үзэл бодлоо бусдад илэрхийлэх, оролцох, хөгжих боловсрох, бусадтайгаа нийтэч байх, аливаа зүйлийг таньж мэдэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах арга зам юм”.

Хүүхдүүдээс авсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнг нэгтгэн үзвэл:

- Цөөн тооны хүүхэд оролцох нь нийгэмших, хөгжих боломжийг нээхээс гадна, өөрийг сорих, туршиж үзэх, тулгарсан асуудлыг цаг хугацаанд нь оновчтой хурдан шийдэх, аав ээж, томчууд, ангийн хамт олон, найз нөхдөдөө үзэл бодлоо илэрхийлэх, надад хамааралтай асуудлаар дуу хоолойгоо хүргэх гэж хариулсан.
- “Оролцоог яагаад чухал гэж бодож байна вэ?” гэсэн асуултад оролцоог хүүхдийн үндсэн эрх мөн гэж тодорхой илэрхийлэхгүй байгаа хэдий ч оролцооноороо аливаа юмыг өөр өнцгөөс харж, шинэ зүйлс таньж мэдэн сэдэлжиж, хийж оролдож үзсэнээр туршлага хуримтлуулж ур чадварт суралцан сайжирч, өөртөө итгэлтэй болж өөрийгөө хөгжүүлдэг гэж хариулсан.
- Мөн олон зүйлд идэвх санаачилгатай оролцооноор бусдын өмнө өөрийгөө зөв илэрхийлж, ойлгуулж сурахаас гадна олон найз нөхөдтэй болж хандлагаа засан өөрийгөө хамгаалж аливаа зүйлсийг зөв талаас нь харах чадвартай, чадамжтай болдог гэж дийлэнх хүүхдүүд үзэж байгаа нь оролцоо ямар чухал бөгөөд хүүхдүүдэд олон сайхан боломжийг олгодог болохыг мэдэж байгаа нь харагдаж байна.

2. Хүүхдийн оролцооны хэлбэрүүд

Хүүхдийг оролцуулна гэдэг бол нийгмийн хөгжилд нөлөөлнө гэсэн үг. Нийгмийн амьдрал дахь хүүхдийн оролцоо гэдэг нэг удаагийн арга хэмжээ, төсөл төдий бусад ажил хэргийн хавсарга ч биш, энэ бол улс, нийгмийг хамарсан ажил үйлсэд түүний үр нөлөө бүрээр илэрхийлэгдэж байдаг олон талын хамтын ажиллагааны уялдаа холбоог шаарддаг үйл явц юм.¹³

Бид судалгааны ажлынхаа хүрээнд хүүхдийн оролцооны зарим хэлбэрүүд хэрхэн ашиглагдаж байна гэдгийг тодруулахыг зорьсон. Тухайлбал: Хүүхдүүд ямар төрлийн /түвшний/ үйл ажиллагаанд ихэвчлэн оролцож байна, хүүхдийн оролцоо сайн дурын үндсэн дээр байж чадаж байна уу, хүүхдүүд өөрсдийн төлөөллийг сонгож чадаж байна уу, хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэх боломж ямар байна, хүүхдүүдийн эрх нь зөрчигдсөн үед хаана хандах вэ, хүүхэд шийдвэр гаргагчидтай харилцах боломж байна уу, сургуулийн болон гэр бүлийн түвшний шийдвэрт оролцох боломж хэр байна зэрэг асуудлуудыг тодруулахыг зорьсон.

№	Оролцооны түвшин	Давтамж	Хувь
1	Гэр бүлийнхээ шийдвэр гаргалтад	272	54,7%
2	Сургуулийн шийдвэр гаргах үйл явцад	250	50,3%
3	Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх шийдвэрт	28	5,6%
4	Шүүхийн үйл ажиллагаанд	51	10,3%
5	Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд	36	7,2%
6	Цахим орчинд	86	17,3%
7	Орон нутгийн хүүхдийн зөвлөл, чуулган	94	18,9%
8	Хүүхэд удирдлагатай, эсвэл залуучуудын байгууллагад	96	19,3%
9	Урлаг соёлын арга хэмжээнд	183	36,8%
10	Сүмийн болон шашны үйл ажиллагаанд	18	3,6%
11	Байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаанд	82	16,5%
12	Дүүрэг, хороо, багийн шийдвэр гаргалтад	29	5,8%
13	Улс төрийн намын үйл ажиллагаанд		
14	ТББ-ын шийдвэр гаргалтад	22	4,4%
15	Орон нутгийн болон үндэсний хэмжээнд кампанит ажилд	12	2,4%
16	Дээрх бүгд		
17	Бусад		
18	Аль нь ч биш	64	12,9%

Эх сурвалж: 2019 оны 11-р сарын 5-22-ны өдрүүдэд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн 497 хүүхдээс авсан судалгааны үр дүн

¹³ Хүүхдийн оролцооны ертөнцөөр аялахуй “Нандана Редди, Ратна Кавита”

Бид судалгааны үр дүнгээ нэгтгэхдээ хүүхдийн оролцооны хэлбэрүүдийг гэр бүлийн, сургуулийн, бусад гэсэн гурван хүрээгээр авч үзлээ.

2.1 Гэр бүлийн орчин дахь хүүхдийн оролцоо

2019 оны 11-р сард судалгаанд оролцсон хүүхдүүдээс гэр бүлийнхээ шийдвэр гаргалтад (54,7%), сургуулийн шийдвэр гаргах үйл явцад (50,3%), урлаг соёлын арга хэмжээнд (36,8%) оролцдог хэмээсэн нь хүүхэд өөрийн амьдарч, сурч буй орчны үйл явцад идэвхтэй оролцдог болохыг харуулж байна. Мөн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд оролцох байдал 18,9%-19,3% байгаа боломжийн үзүүлэлт юм. Харин цахим орчинд оролцох оролцоо 17,3%-ыг эзэлж байгаа зарим судалгаа, мэдээллийн үр дүнтэй харьцуулахад бага үзүүлэлт байна.

Мөн хүүхдүүд байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцдог байдал нь 16,5% -ийг эзэлж байгаа нь тэд зөвхөн өнөөдрийн төлөө биш ирээдүйн төлөө санаа тавьж байгаагийн нэг илрэл юм.

2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д хүүхдүүдээс судалгаа авахдаа мөн хүүхдүүдийн оролцоог гэр бүлийн хүрээнд хэрхэн дэмждэг талаар судалгаа авахад дараах үр дүн гарсан байна.

График 3.4 Хүүхдийн оролцоог гэр бүлийн хүрээнд дэмждэг эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Хүүхдийн оролцоог гэр бүлд хэрхэн дэмждэг вэ? гэсэн асуултад хүүхдүүдийн 60 % нь гэр бүлийн дэмжлэг хангалттай, маш сэтгэл хангалуун байдаг, 19 % нь Сайн дэмждэг бөгөөд мөнгө, материаллаг орчноор түлхүү дэмждэг, 6 % нь хаяа л дэмждэг бөгөөд тийм ч сайн дэмждэггүй. Аливаа үйл ажиллагаанд оролцох болбол тохиролцооны үндсэн дээр хичээлээ сайн хийх, үгэнд сайн орсон тохиолдолд зэрэг

оролцох эрх нээгддэг, 11% нь Дэмждэггүй, дэмжиж урамшуулахаас цааргалдаг гэсэн бөгөөд үлдсэн 4.6 % нь асуултад хариулаагүй байна.

Судалгааны үр дүнгээс харахад дараах нийтлэг асуудлууд гарч ирж байна. Үүнд:

- Хүүхдийн хөгжил оролцоог дэмжих хамгийн анхдагч орчин бол гэр бүлийн орчин бөгөөд нийт хүүхдүүдийн хариултын 79% нь эцэг эхээ өөрсдийг нь хөгжүүлэх оролцуулах тал дээр анхаарч дэмждэг хэмээн хариулсан бол хааяа болон дэмжлэг муу гэж хариулсан хүүхдүүдийн зүгээс эцэг эхчүүдийн хүүхдийн оролцооны талаар ойлголт дутуу, буруу, хэнхэг, хэт их нийгмийн идэвхтэй хүүхдүүд л байдаг гэх мэт хандлагатай байдгийг хүүхдүүд хэлж байна.
- Оролцохын ач холбогдлыг ойлгохгүй, оролцох идэвх сул хандлага ажиглагдаж байна. Зарим судалгаануудад дурдсанаар хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээллийг зөвхөн нийгмийн чиглэлийн хичээлүүдэд дурдаад өнгөрч байгаагаас гадна түүнийг практик үйл явц болгох, хүүхдийг хэрхэн, яаж, оролцуулах арга барил, дадал олгох сургалтад анхаарахгүй байна гэсэн байдаг. Иймд хүүхэд бүхэн оролцох боломжтой, оролцохын ач холбогдлыг эцэг эх, гэр бүлийн орчин, сургууль боловсролын орчин олон нийтэд мэдээлж хүргэх хэрэгтэй байна.
- Мөн эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжил оролцооны чадварыг дэмжиж байгаа ч тэр нь зөвхөн санхүү материаллаг байдлаар илрэх хандлагатай гэж хүүхдүүд үзэж байгаа бөгөөд хүүхдүүд эцэг эхээ тэднийг ойлгож дэмждэг, хүсэл сонирхлыг нь бодитой дэмжиж тэдэнд илүү цаг зарцуулж анхаарал хандуулахыг, том хүн болох гэж буй шилжилтийн насанд явж байгаа гэдгийг ойлгож, хүсэл хэрэгцээг нь хүндэтгэхийг хүсэж байна. Хүүхэд өөрөө саналаа илэрхийлж, гэр бүлийнхэнтэйгээ зөвшилцөхийг хүссэн ч гэр бүлийнхэн нь сонсдоггүй, үл хайхардаг, завгүй ажилтай, хичээлээ л хий гэх мэтээр ханддаг байдал байсаар байна.


- *[Тааруухан дэмждэг. Гэртээ цаг гаргахгүй байна гэдэг. Оролцооны талаар ойлголт бага байдаг];*
- *[Хүүхдийн оролцоог аав ээж асран хамгаалагч нь үнэхээр сайн ойлгосон тохиолдолд бүхий л талаар дэмжих бүрэн боломж бий...]*
- *[Дэмждэг. Гэр бүл нь дэмждэг. Заримдаа хүсэхгүй байхад дэндүү их оролцдог];*
- *[Гэр бүл дэмждэг ч дэндүү их оролцдог. Энэ нь надаа ядаргаатай санагддаг]*
- *[Дэмждэггүй ямар ч үр дүнгүй гэж боддог манай ээж аав огт үр дүнгүй гэж боддог];*
ХОБУЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч хүүхдүүдээс “Гэр бүл, сургууль, амьдарч буй бүхий л орчныхоо шийдвэр гаргах үйл явцад оролцож чаддаг уу?” гэсэн асуултад хүүхдүүдийн дийлэнх олонх нь гэр бүлийн орчинд эцэг эх асран хамгаалагчид хүүхдээ сонсож үзэл бодлын хүндэтгэдэг бөгөөд шийдвэр гаргалтад ямар нэгэн байдлаар оролцож чаддаг гэж хариулсан. Харин зарим гэр бүл хүүхдийг сонсох тал дээр учир дутагдалтай. Жишээ нь секц дугуйланд явах гэхээр санхүү боломжгүй гээд хамруулахгүй, хувцас хэрэглэл сонгох тал дээр шууд өөрсдийн үзэл бодлоо тулгадаг үнэтэй байна чамд зохихгүй гэх мэтээр сэтгэл санааг гутаадаг мөн сонирхлыг минь үл хүндэтгэж мэргэжил сонгох тал дээр ихээхэн зөрчилддөг гэж хариулж байгаагаас үзэхэд эцэг эхчүүд хүүхдийн дуу хоолойг сонсох тал дээр харилцан адилгүй байгаа нь оролцооны талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгааг илэрхийлж байна.

2.2. СУРГУУЛИЙН ТҮВШИН ДЭХ ХҮҮХДИЙН ОРОЛЦОО

Хүснэгт 3.2-д байгаа “Та ямар үйл ажиллагаанд оролцдог вэ?” гэсэн асуултад сургуулийн шийдвэр гаргах үйл явцад гэж 50,3% нь хариулсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтийн нэг бөгөөд энэ асуудлыг бид өмнө нь 2018 оны 06 сарын 16-19-ны судалгаанд оруулан дараах үр дүн гарч байсан.

График 3.5 Сургуулийн дүрэм, журам шийдвэрт хүүхдүүд оролцож чаддаг эсэх



■ Оролцож чаддаг ■ хангалттай биш ■ оролцуулдаггүй ■ огт оролцуулдаггүй ■ Хариулаагүй

Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Сургуулийн дүрэм, журам шийдвэрт хүүхдүүд оролцож чаддаг уу? гэсэн асуултад хүүхдүүдийн 39 % нь оролцож чаддаг, 11 % нь заримдаа оролцож чаддаг ч хангалттай биш байдаг, 8.4 % нь оролцуулдаггүй бөгөөд

сургуулийн багш нийгмийн ажилтан, нөлөө бүхий хүмүүс шийдвэр гаргадаг, 32 % нь огт оролцуулдаггүй буюу Сургуулийн захиргааны асуудал бөгөөд тушаал шийдвэрээр биднээс ангид явдаг ажил гэж ойлгодог гэжээ. Үлдсэн 10% нь асуултад бүрэн хариулаагүй байна.

Шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн байнгын оролцоог жишээлбэл ангийн зөвлөл, сурагчийн зөвлөл, сургуулийн удирдлага дахь сурагчдын төлөөллөөр дамжуулан зөвлөл болон хороон дээр сургуулийн бодлого, зан үйлийн дүрэм зэргийг хэлэлцэхэд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар хангаж болно. Эдгээр эрхийг хуульчилж өгөх шаардлагатай, ингэснээр түүнийг хэрэгжүүлэх эсэх нь тухайн эрх мэдэлтэн, сургуулийн удирдлага, болон эрхлэгч багш сарын сайн дурын асуудал бус, заавал хэрэгжүүлэх заалт болно гэсэн байна.

- *[Уул нь бид нарыг сонсдог, санал хүсэлт авдаг боловч хэрэгжүүлдэггүй];*
- *[Сургуулийн захиргаа өөрсдөө шийдвэр гаргаж тэрхүү шийдвэрийг багш, ажилчид, сурагчид дагаж мөрддөг];*
- *[Хүүхдүүдээс нэмэлт дүрэм оруулмаар байвал бичээрэй гэдэг ч огт оруулдаггүй...]*
ХОБУЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

Хүүхдийг сургуулийн түвшинд ямар шатанд оролцож байгааг тодорхойлох чухал үзүүлэлт бол сургуулийн дүрэм журам шийдвэрт хүүхдүүд оролцож чадаж байгаа эсэх асуудал юм. Хүүхдүүдийн 39% нь оролцож чаддаг гэж хариулсан бөгөөд чанарын судалгаагаар авч үзвэл хүүхдүүд хүүхдийн оролцооны байгууллагад хамрагддаг тул, гишүүн болон дарга, удирдах зөвлөлд явдаг тул оролцож чаддаг гэсэн байр сууринаас хариулсан хариулт зонхилж байв.

Харин оролцож чаддаггүй, заримдаа хааяа үгээ хэлдэг, оролцоо муу гэж үнэлсэн 49% хүүхдүүдийн хувьд сургуулийн дүрэм журам аливаа шийдвэрүүд сургуулийн захирал, менежерүүдийн батлан гаргадаг баримт бичиг бөгөөд бид үүнийг сайн дагаж мөрдөх ёстой гэсэн байр сууринаас хариулж байна. Хүүхдийн хувьд сургуулийн түвшинд ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагддаггүй, “сонсогч”-ийн байр сууриас оролцдог, саналыг нь асуудаг боловч хайхардаггүй хэмээн хариулсан байна. Энэ нь сургуулийн түвшинд хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг оролцуулах механизмыг бий болгох, тэдний санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч, зохих түвшинд шийдвэрлэдэг байх хэрэгтэй гэдгийг харуулж байна.


Мөн өөртөө итгэлтэй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг зөв төлөвшил, ирээдүйтэй идэвхтэй иргэд бэлтгэх орчин болсон боловсролын байгууллагууд хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудыг дэмжин ажилладаг байх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хүүхдийн хөгжил оролцооны талаар бодлогын баримт бичиг салбар дундын хамтын ажиллагаагаар бий болгож мөрдүүлэх, хянах үнэлэх тайлагнах асуудлыг салбар бүр асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох байгууллагуудад хүргүүлдэг болох механизмыг бий болгох шаардлагатай байна.

Энэ тухай Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны 12 дугаар зөвлөмжийн 110-р хэсэгт: “Шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн байнгын оролцоог жишээлбэл ангийн зөвлөл, сурагчийн зөвлөл, сургуулийн удирдлага дахь сурагчдын төлөөллөөр дамжуулан зөвлөл болон хороон дээр сургуулийн бодлого, зан үйлийн дүрэм зэргийг хэлэлцэхэд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар хангаж болно. Эдгээр эрхийг хуульчилж өгөх шаардлагатай, ингэснээр түүнийг хэрэгжүүлэх эсэх нь тухайн эрх мэдэлтэн, сургуулийн удирдлага, болон эрхлэгч багш сарын сайн дурын асуудал бус, заавал хэрэгжүүлэх заалт болно” гэж заасан байдаг.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч хүүхдүүд: Сургуулийн орчинд ангийн дарга сонгох, дугуйлан секцэд хамрагдах шийдвэрт оролцдог. Харин сургуулийн сурагчидтай хамаатай төлөвлөгөө, төсөв, хэлэлцэхэд оролцох байдал маш ховор хүүхдүүдэд хүрч ажилладаггүй. Сургууль дээр байнга юманд оролцдог хүүхдүүдийг хамруулах байдал түгээмэл. Сурагчид өөрсдийн түвшинд хэрхэн яаж оролцох нь тодорхойгүй байдгаас болоод аливаа асуудалд хүүхэд бидний оролцоо байхгүй гэж хэлж болно. Харин ч бидний санаачилсан ажлуудыг хүлээн зөвшөөрөхгүй няцаадаг байдал их байдаг тухай ярилцлагаас үзэхэд сургуулийн удирдах ажилтнууд, багш нарын оролцооны талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сурагчдыг мэдээлэлтэй, зохион байгуулалттайгаар олон хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлж оролцох боломжтой таниулж ойлгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

2.3 ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ БУСАД ХЭЛБЭРҮҮД

График 3.6 Хүүхэд өөрийн сайн дураар оролцдог эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19 нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Өөрийн сайн дураар оролцог уу? гэсэн асуултад хүүхдүүдийн 84 % нь тийм сайн дураараа оролцдог гэж хариулсан бол 8 % нь заримдаа оролцдог, 5% нь оролцдоггүй гэсэн хариулт өгсөн бол үлдсэн 3 % хүүхдүүд хариулаагүй байна. Судалгаанд оролцогч хүүхдүүдээс авсан судалгааны аргачлал нь нээлттэй асуулгын арга байсан тул хүүхдүүд дэлгэрэнгүй судалгаанд оролцогчид өөрийн сайн дураар аливаа үйл ажиллагаанд оролцоход дараах бэрхшээлүүд гардаг талаар хэлж байна. Үүнд:

- Аливаа үйл ажиллагаанд эцэг эх, багш нар, томчууд танил тал, арын хаалгаар оруулдаг тохиолдол байна.
- Аливаа үйл ажиллагааны талаарх зар мэдээ, мэдээлэл муу учраас оролцох боломж, сонирхол байдаггүй.
- Бусдын өмнө өөрийгөө илэрхийлж чаддаггүй, ичиж зовдог, айдаг учраас оролцох сонирхол төрдөггүй.
- Оролцож буй үйл ажиллагааныхаа мөн чанарыг мэдээгүй учраас дараа нь харамсдаг.
- Зарим үйл ажиллагаанд төлбөр төлж оролцуулдаг. Багш нар, эцэг эхийн дарамт шахалтаар орох тохиолдол байна.
- Төлөвлөгдөөгүй үйл ажиллагаа ихээр болдог нь хүүхдийг хүчээр оролцуулахад хүргэж байна.


- [Өөрийн сайн дураар оролцогч гэсэн дараа ямар нэгэн шалтгаанаар сонгосондоо харамсдаг]
- [Оролцдог. Гэхдээ эцэг эхийн болон хүн таньдаг бол арын хаалгаар авчихдаг...]
- [Зарим үед багш нарын дарамт шахалтаар ордог]; [Оролцдоггүй. Учир нь оролцох сонирхол байдаггүй]; [Үгүй, зүгээр ормооргүй санагддаг]; [Үгүй. Өөрөө идэвх муутай...]
- [Тийм, өөрийн сайн дураар оролцдог, Би АХНЗ-хаа дэд тэргүүнд өөрийн сайн дураар оролцож энэ албан тушаалд хүрсэн]; [Оролцдог, лидер сурагчид өөрийн сонирхлоор...]
- [Оролцдоггүй учир нь зараа мэддэггүй учир]; [Үгүй. Урьдчилан хэлдэггүй гэнэт хэлдэг]; [Цахим ертөнцөөс мэдэн сайн дураар оролцдог]; [Янз бүр гэхдээ намайг мэдээгүй байхад оруулчихсан байдаг...]
- [Өөрийн сайн дураараа төлбөр төлж оролцдог]; [Оролцдоггүй хааяа хандив цуглуулдаг...]
ХОБҮЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

Дээрх саналуудаас дараах дүгнэлтийг хийж болно.

- Оролцоо нь сайн дурын үндсэн дээр нийтэд хүртээмжтэй үнэ төлбөргүй байх ёстой боловч, хүүхдүүдээс өөрсийн сайн дураар төлбөр төлж оролцдог гэсэн хариулт гарсан нь оролцох эрх нь хэрхэн хангагдаж байгааг нэг талаас харуулж байна.
- Хүчээр оролцуулах, мөн оролцохын ач холбогдлыг хүүхдүүд ойлгохгүй, мэдээлэл хүртээмжгүй байгаа нь оролцоонд сөргөөр байна.
- Багш, нийгмийн ажилтнууд хүүхдийг оролцуулах аливаа ажилд тэдний хүсэл сонирхлыг харгалзан хүндэтгэж дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэдтэй харилцах нь чухал байна. Уламжлалт хандлагаар захиран тушаах, шууд оноож даалгаж өгөх нь сонгогдсон хүүхдэд ч заримдаа дарамт шахалт болж, бусад хүүхдийг ч мөн ялгаварлан гадуурхаж байгаа хэлбэр гэж хүүхдүүд үзэж байна.
- Асуулгад би дарга нь учир, би удирдагч учир гэсэн агуулга, өнгө аяс олон давтамжтай орж байсан.
- Хэдий хүүхдийн оролцооны байгууллагын хүүхдүүд боловч оролцоо бол хүүхэд бүрд тэгш хүртээмжтэй эдлэх эрх, хөгжих боломж байх ёстой.
- Мэдээлэл хүртээмжгүй болон хүүхдүүдийг аливаа үйл ажиллагаанд оролцуулахдаа урьдчилан хэлж санал хүсэлтийг нь

авах механизм дутмаг байна. Гэнэт болон цаг хугацааг нь тулгаж хэлэх нь хүүхдүүдэд хүндээр тусдаг ба мэдээлэл хүртээмжгүй хүрснээс үүдэн оролцоо нь Рожер хартын онолоор бол 2 болон 3 дах шат болох Хүүхдүүд бэлгэдэл болох, чимэглэл болгож буй зураглалыг гаргаж байна.

График 3.7 Хүүхдүүд төлөөллөө өөрсдөө сонгодог эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19 нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Төлөөллөө өөрсдөө сонгодог уу? гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 67% нь тийм, 7% нь заримдаа буюу бусад хүмүүсийн оролцоотой өөртэй нь хамтарч сонгодог, 9% нь бараг үгүй буюу багш, нийгмийн ажилтан, аав ээж, фракц бүлгийн оролцоотой сонгодог, 11% нь огт үгүй буюу шууд цохож оролцуулдаг гэсэн болон үлдсэн 6% нь хариулаагүй.

Хүүхдүүд өөрсдийн төлөөллийг сонгохтой холбоотой дараах асуудлууд түгээмэл байна. Үүнд:

- Хүүхдүүд өөрт хамаатай аливаа асуудалд өөрсдийн сайн дураар оролцох, төлөөллөө өөрсдийн саналаар сонгоход саад болдог хүчин зүйл нь шударга бус байдал, танил тал, тал тохой татах хандлагаар бусад хүүхдийн оролцох боломжийг хязгаарлаж байна.
- Хүүхдүүд төлөөллийн зарчмаар шударга бөгөөд эрүүл өрсөлдөөнт, сонирхол нэгт бүлэг дотроосоо өөрсдөө төлөөлөх хүүхдээ сонгох боломж зарим талаар хаалттай байгаа нь томчууд эцэг эх, багш, нийгмийн ажилтнуудын хэт их оролцоо, хүүхдийг шийдвэр гаргах чадваргүй гэж ялгаварлах үзэлтэй холбоотой байна.

- [Бид өөрсдийн төлөөллийг өөрсдийн дотроос сонгодог боловч зарим төлөөллийг арын хаалга буюу өөрдөө сонгоогүйгээр орж ирсэн];
 - [Үгүй танилаараа дамжуулах...]
 - Үгүй ихэвчлэн томчуул өмнөөс нь шийдвэр гаргадаг];
 - [Үгүй. Томчууд биднийг шийдвэр гаргах түвшний хүн биш гэж боддог учир];
 - [Бидэнд эрх байгаа, гэхдээ “хүүхэд” учраас биднийг сонсдоггүй...]
 - [Манайх нэг нэгээрээ тоглоод бүгдийг ялсныг нь ахлагчаар сонгодог];
 - [Тийм, өөрөө болон ард түмэн маань сонгуулиар төлөөллөө сонгодог];
 - [Сонгодог. Анги хамт олноороо аливаа тэмцээн уралдаанд оролцох хүүхдүүдийг санал авч сонгодог...]
- ХОБҮЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

График 3.8 Хүүхэд хэвлэл мэдээллээр дамжуулах үзэл бодлоо илэрхийлэх боломжтой эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Хэвлэл мэдээллээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх боломж танай нутагт байна уу? гэсэн асуултад 49 % нь байдаг, 2 % нь байдаг боловч хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхээс айдаг, 5 % нь ихэвчлэн цахим хэлбэрээр оролцдог, 13 % нь тухай хүүхдийн амьдарч буй орон нутагт хэвлэл мэдээллийн хүрэлцээ муу болон саналаа илэрхийлэх боломж хязгаарлагдмал эцэг эх, багш нар зэмлэдэг, 3 % нь хэдий хэвлэл мэдээллээр хүүхдүүдээс санал авч байгаа мэт боловч энэ нь бодит

байдал дээр гуйвагдаж, хэлсэн үгийг нь буруу өөрөөр болгож хөрвүүлдэг гэсэн бол 21 % нь огт байдаггүй гэж хариулсан. Үлдсэн 7 % нь асуултад хариулаагүй.

Оролцогч хүүхдүүдийн 2 хүүхэд тутмын 1 нь хэвлэл мэдээллээр үзэл бодлоо илэрхийлэх эрхэд нь бэрхшээл тулгардаг гэж хариулсан байгаа нь чамлалттай байна. Судалгаагаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг тодорхойлдог Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзүүлэлтээр Монгол улс 2017 онд 180 орноос 69 дүгээрт жагсаж Монголын хэвлэлийн эрх чөлөөний төлөв байдал Хагас эрх чөлөөтэй хэмээн үнэлэгдсэн тухай дурдсан байдаг. Энэхүү хэвлэлийн эрх чөлөөний асуудал хүүхдийн эрхэд ч мөн сөргөөр нөлөөлж байгааг энэхүү судалгаа давхар харуулж байна.


- *[Багш нар том хүний юм ярилаа гэж загнадаг];*
 - *[Байхгүй тийм боломж бага байсан ч биднийг үл тоодог];*
 - *[Хүүхдүүдээс ярилцлага авдаггүй, хүүхдүүдийг юм мэдэхгүй гэж боддог. Насны гадуурхал байдаг...]*
 - *[Тийм, гэхдээ зарим нөхцөлд өөрсдөдөө хэрэгтэй үед л боломж олгодог];*
 - *[Үгүй дамжуулсан ч зарим яг хэрэгтэй зүйлийг сэтгүүлчид хасдаг];*
 - *[Байхгүй. Учир нь том хүмүүс л хэлдэг. Учир нь хүмүүс хүүхдүүдийг буруу зүйл ярина гэж өөрсдийн бичсэн тестийг өгч цээжлүүлдэг];*
 - *[Хэвлэл мэдээллээр дамжуулна гэвэл хэцүү, өөрийн цахим хэрэгслээр л үзэл бодлоо илэрхийлэхгүй бол хэвлэл мэдээллээр илэрхийлнэ гэдэг бол хэцүү...]*
- ХОБУЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...*

Хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхтэй холбоотой дараах асуудлууд нийтлэг ажиглагдаж байна. Үүнд:

- Томчууд хүүхдүүдийг тусгаарлаж үзэл бодлыг нь хүндэтгэхгүй байх тохиолдол байна. Учир нь хүүхэд байж том хүний юм ярилаа хэмээн загнадаг байна. Үүнийг дагаад хүүхдүүд ч мөн өөрсдийгөө үг хэлж, үзэл бодлоо илэрхийлж болохгүй. Үзэл бодлоо хэвлэл мэдээллээр дамжуулан илэрхийлэх боломж зөвхөн насанд хүрэгчдэд байдаг гэж ойлгон өөрсдөө үзэл бодлоо илэрхийлж, хэвлэл мэдээллээр дамжуулж үгээ хэлэх эрхтэй гэдгийг мэдээгүй байх тохиолдлууд гарч байна.
- Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх мөн л хэвлэл мэдээллийн орчинд хязгаарлалт, хаагдмал байдалтай тулгарч байна. Учир нь хүүхдүүдийн хэлэх үгийг урьдаас бэлдэж өгөх, баяр ёслол, хүүхэдтэй холбоотой баярын үеэр бэлгэдэл болгон ашигладаг гэсэн хариултууд цөөнгүй гарч байна. Хүүхдүүдийн дунд үгээ хэлж, үзэл

бодлоо илэрхийлэх боломжтой хамгийн тохиромжтой орчин бол цахим орчин болсон байна.

График 3.9 Хүүхэд эрх нь зөрчигдвөл хэнд хаана хэрхэн хандахаа мэддэг эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Хүүхэд эрх нь зөрчигдвөл хэнд хаана хандахаа мэддэг үү? гэсэн асуултад нийт хүүхдүүдийн 85% нь мэднэ, 6% нь дунд зэрэг мэднэ, 7% нь мэдэхгүй гэж хариулсан бол үлдсэн 2% асуултад хариулаагүй байна.

Нийт хүүхдийн 85% нь эрх нь зөрчигдвөл хаана хандахаа мэднэ гэж хариулсан нь маш сонирхолтой үр дүн бөгөөд энэ нь судалгаанд оролцогч хүүхдүүдийн онцлогоос мөн шалтгаалсан байх боломжтой. Учир нь тус судалгаанд оролцсон хүүхдүүдийн дийлэнх хувь нь Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын гишүүн хүүхдүүд юм.

(Энэ төрлийн өөр бусад судалгаанд эсрэгээрээ үр дүн муу гарсан байна. 2017 оны Өсвөр үеийн дуу хоолой судалгаанд Сэтгэл санааны хувьд тогтворгүй байвал хаана, хэнд хандахаас мэдэх үү? Гэсэн асуултад оролцогчдын 71.8% нь мэдэхгүй, гэртээ асуудалтай байгаа бол хаана хэнд хандахаа 82.8% нь мэдэхгүй, чи эсвэл чиний танил хүчирхийлэл, заналхийлэлд өртсөн, гэмт хэрэгт холбогдсон бол хаана хэнд хандахаа 86.8% нь мэдэхгүй, дарамтлуулж, шоовдорлуулсан бол мөн хаана хэнд хандахаа мэдэхгүй гэж 84.2% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Тус судалгаанд оролцогчдын онцлог нь нийт 422 хүүхэд хамрагдсанаас 76.5 хувь нь ЕБС-д сурдаг 3-11-р ангийн сурагчид, 23.5 хувь нь зорилтот бүлгийн хүүхдүүд байсан)


- [Тийм мэднэ. Эцэг эх, нийгмийн ажилтан, хүүхдийн утас 108, орон нутгийн удирдлага]; [Мэднэ. Нийгмийн ажилтан, хүүхдийн байцаагч, 108, гэр бүл]; [Тийм. Эцэг эх, нийгмийн ажилтан, хүүхдийн утас 108, орон нутгийн удирдлага...]
- [Хаана хандахаа мэддэг боловч ямар үр дагавар гарахаас айж төдийлөн хэлж чаддаггүй], [108 бүрэн хариулдаггүй. Зарим үед тоглоод байна гээд тасалдаг], [Хэнд хандахаа мэддэг боловч тэр хүндээ хэрхэн ханддагаа харахан мэддэггүй...]

ХОБҮЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

Судалгаанд оролцсон хүүхдийн 91 % нь эрх нь зөрчигдвөл хаана хандахаа мэддэг болон дунд зэрэг мэднэ гэж байгаа боловч оролцогч хүүхдүүдийн дунд асуудлаа хэлэхээс айх, нууц нь задрахаас, бусдад итгэхгүй байх хандлага цөөнгүй байна. Мөн нийт хүүхдийн хаашаа хандахаа мэднэ гэж хариулсан хүүхдүүдээс хүүхдийн тусламжийн утсанд хандана гэж хариулсан хариулт хамгийн өндөр хувиар нэрлэгдсэн байна. Тусламжийн утсанд хүүхдүүд хандаж болно гэдэг мэдээлэл өндөртэй байгаа ч хэрхэн хандахаа төдийлөн мэддэггүй, мэдээлэл хомс байдаг тухай хариултууд ирүүлсэн.

- Иймд тусламжийн утасны мэдээллийг олон нийт, тэр дундаа хүүхдүүд, өсвөр насныханд түгээх, Утасны үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудын ур чадварыг улам нэмэгдүүлэх, ажлын байран дээрх сургалт, мэргэжлийн арга зүйн сургалтуудыг тогтмол зохион байгуулах, дуудлагын ангиллуудыг тогтоох, чимээгүй дуудлага болон хуурамч дуудлагуудыг нарийн ялгах, кейс бүрдүүлэлт ашиглалтын сургалтуудыг зохион байгуулж чадавхжуулах шаардлагатай байна.


График 3.10 Таны эрх зөрчигдсэн үед хаана хандах вэ?



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Нийт хүүхдийн 85% нь эрх нь зөрчигдвөл хаана хандахаа мэднэ гэж хариулсан хүүхдүүдийн 21% нь эцэг эх гэр бүлдээ мэдэгдэнэ, 31.5 % нь Нийгмийн ажилтан, багш сургуулийн ажилтанд мэдэгдэнэ, 35.9 % нь Хүүхдийн тусламжийн утас болон хүүхдийн байгууллагад хандана, 11.6 % нь цагдаад мэдэгдэнэ гэж хариулсан байна.

График 3.11 Хандах сувгийн тоо




Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Мөн мэднэ гэж хариулт ирүүлсэн хүүхдүүдээс ирүүлсэн хариулсан нэг хандах суваг нэрлэсэн 107 хүүхэд, 2 хандах суваг нэрлэсэн 136 хүүхэд, 3 хандах суваг нэрлэсэн хүүхдийн тоо 151, 4 хандах суваг нэрлэсэн хүүхдийн тоо 58, 5 хандах суваг нэрлэсэн 13 хүүхэд байв. Хүүхдүүдийн ерөнхий мэднэ гэж хариулсан 465 хүүхдийн 222 нь буюу 47.7 % нь 3 буюу түүнээс дээш хандах суваг буюу хандах хүн, байгууллагыг бодитой нэрлэж байна.

Оролцогч хүүхдүүд эцэг эх гэр бүлдээ, багш нийгмийн ажилтандаа хандана гэсэн нийтлэг хариултуудаас гадна хүүхдүүд шийдвэр гаргах түвшний субъектүүд, хүүхдийн эрхийн байцаагч, хүүхдийн утас, цагдаа зэрэг олон хандах суваг (хандах хүн, байгууллага)-г бодитой нэрлэж чадаж байна.

График 3.12 Хүүхэд шийдвэр гаргагчид захиа бичих, уулзах боломжтой эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Хүүхэд шийдвэр гаргагчдад захиа бичих, уулзах боломж бий юу гэсэн асуултад нийт хүүхдүүдийн 48.4 % нь боломжтой, 8 % нь “Байдаг боловч хүүхдүүд өөрсдөө томчуудыг ашиглахгүй ойшоохгүй гэж боддог мөн өөрсдөө санаачилж бичихээс эмээдэг”, 5.9 % нь хааяа гэсэн бол 11.5 % нь “Боломж, хаалттай, бодит байдал дээр үйл ажиллагаа болж хэрэгждэггүй”, 16.1 % нь “Огт боломжгүй их ажилтай завгүй болон, хүүхэд гэх хандлагаар тоодоггүй” гэсэн хариулт, үлдсэн 10.1 % нь асуултад хариулаагүй байна.

Захиа бичсэн ч хүндээ очдог болов уу? гэсэн асуултауд олноор ирсэн ба хүүхдийн санал, өргөдөл гомдол, шийдвэр гаргах түвшинд хүүхдийг оролцуулдаг механизм манай оронд бүрэн бүрдээгүй байна. Хүүхдүүд өгсөн санал нь бодит үр дүн болж хэрэгждэг эсэх талаар мэдээлэлгүй, энэ тал дээр нэлээд гутранги хандлагатай байгаа ба мөн насанд хүрэгчдийн хандлага хүүхдүүдийг үл ойшоох, ялгаварлах шинжтэй байна гэж хүүхдүүд үзжээ.

График 3.13 Хөндлөнгийн нөлөө, дарамтгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх боломжтой эсэх



Эх сурвалж: 2018 оны 06 сарын 16-19-нд зохион байгуулсан “Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн”-д оролцогчдоос авсан судалгааны үр дүн

Хөндлөнгийн нөлөө, дарамтгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх боломж бий юу? Гэсэн асуултад хүүхдүүдийн 65% нь бүрэн боломжтой, 3% нь боломж байгаа ч итгэлгүй байдаг, 8% нь заримдаа буюу биднийг чадвар чадамжгүй гэж үздэг, 9.3% нь бараг байхгүй буюу хязгаарлагдмал боломжтой, 9 % нь огт байхгүй бөгөөд хөндлөнгийн нөлөө дарамтгүйгээр үзэл бодлоо илэрхийлж чадахгүй дарамтад ордог гэсэн агуулга бүхий хариултауд өгсөн бол үлдсэн 6 % нь асуултад хариулаагүй байна.

- *[Байдаг. Хааяа анги дээр хүүхдүүд намайг доромжилдог. Багш, нийгмийн ажилтанд хэлэх гэхээр ангийн хүүхдүүд дарамталж айлгадаг];*
- *[Гэхдээ зарим хүүхэд үзэл бодлоо илэрхийлэхээс эмээдэг. Учир нь хэн загнах бол, хэн буруутгах бол гэхээс айдаг];*
- *[Чаддаггүй. Сэтгэлийн дарамтад ордог];*
- *[Заримдаа учир нь зарим нэг сургалт уулзалтад суухад багш болон сургуулийн захиргааны хүмүүс хэлэх үгийг нь бэлдээд өгчихдөг];*
- *[Бий гэвч зарим тохиолдолд бусдын нэр хүндийг өсгөх сурталчилгаа болдог];*
- *[Байхгүй ямар нэг зүйл хэлэх гэхээр томчууд тэгж болохгүй тэгвэл манайх асуудалд орно гэдэг];*
- *[Ховор. Өөрийнхөөрөө илэрхийлэх гэхэд уурладаг заавал зөв хариулт шаарддаг...]*

ХОБҮЗ-нд оролцогч хүүхдүүдийн саналаас...

Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх боломжтой холбоотой дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхээс эмээж байна. Учир нь буруу хэлэх вий гэхээс, хэлсэн үгнээс нь болж дараа нь өөрт нь дарамт, дээрэлхэл, сөрөг хандлагатай тулгарахаас айж байна.
- Хөндлөнгийн нөлөө дарамтгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх бүрэн боломжтой гэж нийт хүүхдүүдийн 65% нь хариулсан хэдий ч хүүхдүүдийн багагүй хувь нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, оролцох эрх нь бүрэн хангагдахад саад бэрхшээл учирч байна хэмээн үзжээ.

3. Орон нутгийн байгууллагын хүүхдийн оролцооны үнэлгээ

Орон нутгийн байгууллагууд хүүхдийн оролцоонд тавигддаг ерөнхий шалгууруудыг хэрхэн баримталж байгаад үнэлгээ хийлгэх зорилгоор насанд хүрэгчдээс 9-н асуулт, 27-н үндсэн шалгуур бүхий судалгааг авч үр дүнг нэгтгэн гаргасан.

1-шалгуурыг харгалзан үзээгүй, 2-шалгуурыг мэдэж байгаа ч практикт тусгаагүй, 3-шалгуурыг биелүүлэхээр хүчин чармайлт гаргасан ч зохион байгуулалтын ямар ч журамгүй, 4-бүх ажилтан шалгуурыг бүрэн ойлгож, хэрэгжүүлж шалгасан, 5- мэдэхгүй

Ерөнхий асуулт	Оролцооны шалгуур	1	2	3	4	5
1.Оролцоо ил тод, мэдээлэлтэй байсан уу?	1.а. Хүүхдүүдэд оролцох эсэхээ шийдэхэд нь тус болохын тулд хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэл өгсөн үү?	21%	26%	25%	23%	5%
	1.б. Хүүхдэд ээлтэй байдлаар тэдэнд ойлгогдох хэлээр мэдээлэл түгээсэн үү?	14%	20%	26%	33%	7%
	1.в. Холбогдох хүн бүрд үүрэг, хариуцлагыг нь тодорхой тайлбарлаж ойлгуулсан уу?	14%	23%	23%	34%	5%

Оролцооны үндсэн асуудал бол мэдээлэл нээлттэй ил тод, ойлгомжтой байхад оршдог. Орон нутгийн байгууллагуудын энэхүү шаардлагыг хэрхэн хангаж байгаад насанд хүрэгчид дээрх үнэлгээг өгсөн байна. Мэдээлэл түгээж буй байдалд харилцан адилгүй буюу 21%-26% жигд үнэлгээ өгсөн байгаа нь нэг талаас мэдээлэл хүргэх сувгийн ашиглалт орон нутгуудад харилцан адилгүй байдагтай холбоотой гэж үзэж болно. Харин хүүхдүүдэд мэдээлэл түгээхдээ ойлгомжтой, тодорхой үг хэллэгээр тайлбарладаг байдал 33%-34% -ийг эзэлж байна.

2.Оролцоо нь сайн дурын үндсэнд суурилсан уу?	2.а. Хүүхдүүд сайн дураараа оролцсон уу?	9%	18%	22%	40%	11%
	2.б. Тэдэнд оролцох эсэхээ шийдэх хангалттай хугацаа, мэдээлэл өгсөн үү?	10%	21%	28%	35%	6%
	2.в.Тэд хүссэн үедээ хөтөлбөрт оролцохоо болих боломжтой юу?	13%	15%	33%	28%	11%

Ардчилсан нийгэмд иргэн хүний оролцоо нь тэдний үндсэн эрх бөгөөд энэ утгаараа оролцох нөхцөл бололцоог хангах нь төрийн үүрэг байдаг бөгөөд тэр боломж бүрдсэн үед оролцох нь тэдний эрхийн, сайн дурын асуудал байдаг. Судалгаанд оролцогчдын 62% нь 1/3 болон 4/ хүүхдийн оролцоо сайн дурын үндсэн дээр явагддаг хэмээн үзсэн бол бидний өмнө өгүүлсэн судалгаан дээр хүүхдүүдийн 84% нь бид сайн дураараа оролцож чаддаг хэмээн үр дүн гарсан талаар дурдсан.

3.Оролцоог нь хүндэтгэсэн үү?	3.а. Хүүхдийн сурах ажиллах, тоглох г.м цаг завьг харгалзан үзсэн үү?	15%	17%	32%	30%	6%
	3.б. Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үед хүүхдүүдтэй хамтран ажиллах замаар хэлэлцсэн үү?	11%	20%	25%	34%	10%
	3в. Хүүхдийн оролцоог эцэг эх асран хамгаалагчид, багш нь дэмжсэн үү?	6%	19%	24%	43%	8%
Оролцооны онолын үүднээс авч үзвэл хүүхдийн оролцоонд дэмжлэг болон тэднийг оролцож чадна гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал чухал байр суурийг эзэлдэг. Хүүхдийн оролцоог эцэг эх асран хамгаалагчид, багш нар дэмждэг байдал 67% /3 болон 4/ байгаа нь нэлээд эерэг байдлыг илтгэн харуулж байна.						
4.Оролцоо хамааралтай байж чаддаг уу?	4.а. Хүүхдүүдийн амьдралд тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаа юу?	12%	18%	25%	36%	9%
	4.б. Өөрсдөд нь хамааралгүй үйл ажиллагаанд оролцоо гэж томчууд хүүхдүүдэд ямар нэг дарамт шахалт үзүүлдэг үү?	12%	26%	23%	27%	11%
	4.в. Тухайн үйл ажиллагаа хүүхдүүдийн чадвар, сонирхолд ашиг тус өгч байна уу?	9%	21%	27%	28%	15%
Хүүхдийн амьдралд тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаа байдал 61% /3 болон 4/, хүүхдэд дарамт шахалт үзүүлдэггүй байдал 50% /3 болон 4/, хүүхдийн чадвар сонирхолд ашиг тусаа өгч буй байдал 55% /3 болон 4/ байгаа нь насанд хүрэгчдийн зүгээс оролцоонд эерэг үнэлгээ өгч байгаагийн илрэл юм.						
5.Хүүхдэд ээлтэй байсан уу?	5.а.Хүүхдүүдэд ээлтэй аргачлал, арга ашигласан уу?	11%	16%	23%	39%	11%
	5.б.Хүүхдүүдийн өөртөө итгэх итгэлийг бий болгох, үүний дотор охид ба хөвгүүдийн нас болон чадварын ялгааг тэнцүүлэх аргуудыг ашигласан уу?	15%	21%	24%	29%	11%
	5.в.Хүүхдүүдэд тодорхой тохиромжтой газар уулзалтуудаа зохион байгуулж чадсан уу?	12%	25%	23%	31%	9%
	5.г.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эдгээр газарт очих боломжтой байсан уу?	14%	22%	26%	26%	12%

Хүүхдэд ээлтэй орчин гэдэг нь оролцооны үүднээс авч үзвэл материаллаг гэхээсээ илүү технологи арга хэрэгслийн хувьд тэдний онцлогт тохирсон байхыг хэлдэг. Энэ нь нэг талаас хүүхдийн оролцох боломжийг хэрхэн зөв, оновчтой бий болгосонтой шууд холбоотой юм. Судалгаанд оролцогчид орон нутгийн байгууллагуудыг энэ тал дээр мөн л нэлээдгүй эерэг үнэлсэн нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал: Хүүхдэд ээлтэй аргачлал ашигладаг байдал 62% /3 болон 4/, хүүхдийн нас, чадварын ялгаатай байдлыг харгалздаг байдал 53% /3 болон 4/, хүүхдэд тохиромжтой газар ашигласан байдал 54% /3 болон 4/, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эдгээр газарт очих боломжтой байсан байдлыг 52% /3 болон 4/ хэмээн үзжээ.

6. Тэгш оролцоог хангасан уу?	6.а.Ялгаварлан гадуурхал гарахаас сэргийлж эмзэг бүлгийн хүүхдүүд /охид хөвгүүд/ оролцохыг дэмждэг үү?	13%	18%	25%	37%	7%
	6.б.Аль ч орон нутаг, давхаргын хүүхдийн нөхцөл байдал, соёлын онцлог мэдрэмжтэй ханддаг уу?	11%	22%	24%	35%	8%

Оролцох нөхцөл боломжийг бий болгоход зайлшгүй анхаарч үзэх ёстой зүйл бол тухайн орон нутгийн соёл, ёс заншил, ялгаатай байдал зэргийг харгалзан үзэх хэрэгтэй байдаг. Нөгөө талаар оролцооны тэгш боломжийг хязгаарладаг зүйл нь ялгаварлан гадуурхах явдал юм. Эдгээрийг орон нутгийн байгууллага дээр харгалзан үздэг байдлыг 59%-62% /3 болон 4/ хангадаг гэж үзсэн байна.

7.Томчуудыг сургалтад хамруулан хүүхдийн оролцоог дэмжсэн үү?	7.а.Хүүхэдтэй ажиллах зохих ёсны чадвар, мэдлэгийг ажилтнууддаа олгосон уу?	5%	22%	27%	37%	9%
	7.б.Хүүхдийн оролцоог хөхүүлэн дэмжих итгэл албан хаагчдад байгаа юу?	12%	14%	27%	37%	10%
	7.в.Ажилтнууд хүүхдийн оролцоог нийгэмд, нийтийн дунд үр дүнтэйгээр дэмжиж чадах уу?	7%	18%	32%	36%	7%

Өмнө өгүүлсэнчлэн оролцооны тэр дундаа хүүхдийн оролцоонд тулгардаг нэг том бэрхшээл нь хүүхдүүдийг оролцож чадна, шийдвэр гаргаж чадна хэмээн хүлээн зөвшөөрч итгэл үзүүлэх насанд хүрэгчдийн хандлага хамгийн чухал билээ. Энэхүү судалгаанд насанд хүрэгчид хүүхдийг хүлээн зөвшөөрч дэмжих хандлага сайн байгааг үр дүнгээс нь харж болно.

8.Оролцоо нь аюулгүй, эрсдэлийг урьдчилан тооцоолсон уу?	8.а.Хүүхдүүд хөтөлбөрт оролцохдоо аюулгүй байж чадах уу?	5%	22%	22%	44%	7%
	8.б.Хүүхдүүдийг аюулгүй байлгах арга зам, тэдэнд учирч болзошгүй эрсдэл бий юу?	6%	30%	29%	27%	8%
	8.в.Хэрвээ тухайн үйл ажиллагаанд оролцож байхдаа аюул занал мэдэрсэн бол хаанаас тусламж эрэхээ хүүхдүүд мэдэж байгаа юу?	13%	24%	27%	32%	4%
Аливаа үйл ажиллагаанд эрсдэлийг урьдчилан тооцох нь үйл ажиллагааны найдвартай, үр дүнтэй явагдах үндсэн хүчин зүйлс болохоос гадна оролцогчдын аюулгүй байдлын чухал үзүүлэлт юм. Ялангуяа хүүхдүүдийн хувьд энэ нь нэн чухал асуудалд орно. Судалгааны үр дүнг харахад хөтөлбөрт оролцоход хүүхдийн аюулгүй байдлыг хангаж чаддаг байдлыг 66% /3 болон 4/ гэж үнэлсэн байна.						
9.Томчууд хариуцлагатай байж, оролцож байгаа хүүхдүүдэд эргэж мэдээлэл өгдөг үү?	9.а.Оролцооны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, мөрөөр нь арга хэмжээ авдаг уу?	10%	20%	37%	27%	6%
	9.б.Тэдний санал, үзэл бодлыг хэрхэн үйл ажиллагаандаа тусгаснаа мэдээлдэг үү?	9%	28%	26%	33%	4%
	9.в.Хүүхдийн оролцооны хяналт шинжилгээ үнэлгээг хүүхдүүдтэй хамтран хийдэг үү?	10%	24%	30%	27%	9%
Аливаа үйл явцыг хэмжих нэг үзүүлэлт нь түүнд үнэлгээ дүгнэлт хийн түүний мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авахад оршдог. Судалгаанд оролцогчид энэ байдлыг 64% /3 болон 4/ хэмээн үнэлжээ. Оролцооны онолын хувьд хүүхдүүдээс хүлээн авсан санал, үзэл бодлыг сонсож хүлээн авах нь эхний үе шат бөгөөд тэдний санал бодол байр суурийг хэрхэн тусгаснаа эргэн тэдэнд мэдэгддэг тогтолцоо байсан цагт оролцоо ахисан түвшинд гарч байгааг илтгэдэг. Судалгаанд оролцогчид энэ байдлыг 59% /3 болон 4/ гэж үнэлжээ.						

Эх сурвалж: 2019 он 11-р сарын 5-22-ны өдрүүдэд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн 497 хүүхдээс авсан судалгааны үр дүн

4. Хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудал

Оролцоонд тулгамдаж буй асуудлуудыг дараах 4-н үндсэн асуудлын хүрээнд авч үзлээ. Үүнд:

1. Нийгмийн тогтолцоотой хамааралтай асуудлууд
2. Бодлого, эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудлууд
3. Насанд хүрэгчдийн ойлголт, хандлагатай холбоотой асуудлууд
4. Оролцогч хүүхдүүдээс хамаарсан асуудлууд

Бид судалгааны мэдээлэл цуглуулах явцдаа хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудал /хүснэгт 3.4./ болон үзэл бодлоо илэрхийлэх, оролцоход ямар бэрхшээл тулгардаг /хүснэгт 3.5./ гэсэн 2 асуудлын хүрээнд 20 төрлийн асуудлыг тодорхойлохыг зорьсон. Мөн судалгаандаа насанд хүрэгчдээс “танай орон нутгийн байгууллагад хүүхдийг оролцуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн нээлттэй асуултаар судалгаа авч үр дүнг нэгтгэсэн.

Мөн насанд хүрэгчдийн 6 удаагийн /нийт 60 хүн оролцсон/, хүүхдүүдийн 7 удаагийн /нийт 70 хүүхэд оролцсон/ фокус бүлгийн ярилцлагуудаар хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон.

Хүснэгт 3.2 Хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудлууд

№	Танай орон нутаг/сургуулийн орчинд дараах тохиолдлууд гардаг уу?	Тийм	Үгүй	Хааяа	Мэдэхгүй
1	Аль үйл ажиллагаанд ямар хүүхэд орохыг бид нартай зөвлөлдөхгүй шийддэг	24,7%	34,4%	39%	1,8%
2	Өмнө нь орж байсан хүүхдүүдийг л дахин дахин оруулдаг	43,7%	32,2%	24,1%	
3	Хүсээгүй байхад нь албадан оролцуулдаг	8%	72,4%	19,5%	
4	Үйл ажиллагаанд оролцуулахын тулд хичээл таслуулах, тохиромжгүй цагт, завгүй үед зохион байгуулдаг	7,6%	67,4%	24,9%	0,1%
5	Хүүхдэд холбогдолгүй сэдэвтэй үйл ажиллагаанд оролцуулдаг	6,6%	81,1%	12,3%	
6	Хүүхдэд ойлгомжгүй үг хэллэг ашиглах, очих боломжгүй хол газар зохион байгуулдаг	6,6%	70,2%	23,1%	0,1%
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулахгүй орхидог	32,8%	49,9%	17,3%	
8	Хүүхдүүдийг ялгаварлан гадуурхдаг	16,9%	65,2%	17,9%	
9	Хүүхэдтэй ажиллаж буй томчууд үгэнд орохгүй байна гэж бие махбодын болон сэтгэл санааны дарамт, шийтгэл хэрэглэдэг	10,9%	54,7%	34,4%	
10	Үзэл бодлоо илэрхийлсэн хүүхдүүдийг буруутгадаг	5,4%	64,4%	30,2%	
11	Хүүхдийн бүлгийг хэрхэн, ямар хугацаанд дэмжих талаар тодорхой мэдээлэл өгөхгүй байх,	11,9%	57,5%	30,6%	
12	Биднээс ямар нэг зүйл асуусныхаа дараа үр дүнг нь эргэж мэдээлдэггүй	26,2%	47,7%	26,2%	

Эх сурвалж: 2019 он 11-р сарын 5-22-ны өдрүүдэд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн 497 хүүхдээс авсан судалгааны үр дүн

Хүснэгт 3.3 Танд өөртөө хамааралтай бүхий л асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, оролцоход ямар бэрхшээл тулгардаг вэ?

№	Бэрхшээлүүд	1-р сонголт		2-р сонголт		3-р сонголт	
		Давтамж	Хувь	Давтамж	Хувь	Давтамж	Хувь
1	Оролцооны талаар ойлголт мэдлэг хомс	116	23,3%				
2	Хэрхэн яаж оролцохоо мэддэггүй	111	22,3%	28	5,6%	1	0,2%
3	Мэдээлэл байдаггүй	50	10,1%	35	7%	11	2,2%
4	Хэнд хандахаа мэддэггүй	67	13,5%	72	14,5%	13	2,6%
5	Үзэл бодлоо илэрхийлэхээс айдаг	63	12,7%	57	11,5%	29	5,8%
6	Томчууд сонсдоггүй	80	16,1%	148	29,8%	40	8%
7	Сонссон ч ач холбогдол өгдөггүй			136	27,4%	191	38,4%
8	Оролцох боломж, орчин байдаггүй			11	2,2%	202	40,6%
9	Мэдэхгүй	9	1,8%	10	2%	10	2%

Эх сурвалж: 2019 он 11-р сарын 5-22-ны өдрүүдэд 13 аймаг, нийслэлийн 5 дүүргийн 497 хүүхдээс авсан судалгааны үр дүн

4.1. НИЙГМИЙН ТОГТОЛЦООТОЙ ХАМААРАЛТАЙ АСУУДЛУУД

Энэ нь сургууль, орон нутаг, хүүхдийн оролцооны байгууллага, улс үндэсний болон олон улсын түвшний үйл ажиллагааны болон шийдвэр гаргах, мэдээлэл түгээх зэрэг тогтолцооноос хамаарсан бэрхшээлүүд юм.

Танай орон нутаг, сургуулийн орчинд аль үйл ажиллагаанд ямар хүүхэд оролцохыг бид нартай зөвлөлдөхгүй шийддэг гэсэн асуултад тийм гэж 24,7%, хааяа гэж 39% хариулжээ. Ардчилсан нийгэм дэх оролцооны үндсэн зарчим нь иргэн хүн өөрт хамааралтай шийдвэр гаргах үйл явцын талаар мэддэг, оролцдог байх нөхцөл боломжийг бий болгох асуудал байдаг. Тэгвэл энэ зарчим зөрчигдөж байгааг дээрх судалгааны үр дүн харуулж байна.

Үйл ажиллагаанд оролцуулахын тулд хичээл таслуулах, тохиромжгүй цагт, завгүй үед зохион байгуулдаг 24,9% /хааяа/, хүүхдийн бүлгийг хэрхэн, ямар хугацаанд дэмжих талаар тодорхой мэдээлэл өгөхгүй байх явдал тийм 11,9%, хааяа 30,6% гэж хариулсан бол биднээс ямар нэгэн

зүйл асуусныхаа дараа үр дүнг нь эргэж мэдээлдэггүй гэсэн асуултад 26,2% нь тийм, 26,2% нь хааяа гэжээ. Оролцооны онолын үүднээс авч үзвэл мэдээлэл нь өмнө өгүүлсэнчлэн оролцооны үндэс болохынхоо хувьд нээлттэй ил тод байх, мэдээлэл хүлээн авах, түгээх үйл ажиллагаа нь тодорхой, нээлттэй байх, иргэдээс авсан саналыг хэрхэн тусгасныг мэдээлдэг тогтолцоотой байхыг шаарддаг. Тэгвэл эдгээр зарчим зөрчигдөж байгааг судалгаа харуулж байна.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч насанд хүрэгчдээс “Таны ажиллаж буй салбарт хүүхэд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломж байдаг уу?” гэсэн асуултад бараг нийтээрээ тийм боломж байдаг гэж хариулсан боловч хэрэв тийм бол ямар арга замаар хэрхэн үзэл бодлоо илэрхийлдэг вэ гэсэн асуултад сургалт, спорт, урлагийн үйл ажиллагаанд оролцуулах гэж хариулсан. Харин хүүхдийн байгууллагад ажилладаг хүмүүсийн төлөөлөл хүүхдийн оролцооны талаар арай илүү ойлголт мэдлэгтэй болох нь ажиглагдсан. Хүүхдийн чиглэлээр ажилладаг байгууллагууд хүүхдэд ээлтэй аргачлал, арга ашиглан хүүхдийн оролцоог нийгэмд үр дүнтэй дэмжин ажилладаг гэж тэд үзэж байна. Мөн “Хүүхдийг оролцуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн асуултад хүүхдийг оролцуулах орчин, цаг хугацаа, хөрөнгө санхүү, боловсон хүчин, томчуудын ойлголт хандлага, тэдэнд оновчтой зөв мэдээлэл өгдөггүй, ялгаварлан гадуурхдаг, зарим тохиолдолд үзэл бодлоо илэрхийлсэн хүүхдийг буруутгадаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг орхигдуулдаг гэсэн бэрхшээл байгааг илэрхийлсэн.

4.2. БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Судалгаанд оролцогчид “Танай орон нутаг, сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулахгүй орхидог уу?” гэсэн асуултад тийм гэж 32,8%, хааяа гэж 17,3% нь хариулжээ. Энэ нь орон нутаг болон сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулахгүй орхидог тохиолдол нэлээдгүй байгааг нэг талаар харуулж байгаа юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцооны бодлого, эрх зүйн зохицуулалтай ч холбоотой гэж үзэж болно.

Мөн хүүхдүүд оролцох боломж, орчин байдаггүй гэсэн асуудлыг 42,8% нь бэрхшээлтэй зүйл гэж үзжээ. Насанд хүрэгчдээс “Танай орон нутгийн байгууллагад хүүхдийг оролцуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн нээлттэй асуултыг асуухад хамгийн олон давтамжтай байсан хариултын нэг нь “Хүүхдэд зориулсан тусгай орчин бүрдээгүй, танхим хөгжүүлэх газар, оролцоог хангах орчин, нөхцөл байр сууцны асуудал хомс” гэсэн байв.

Насанд хүрэгчдээс авсан “Танай орон нутгийн байгууллагад хүүхдийг оролцуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн нээлттэй асуултын олон давтамжтай хариултад “Хүүхдийн оролцоог хангах бодлого, хууль тогтоомж, журам гараагүй, хууль эрх зүйн мэдлэг дутмаг байдал” гэсэн хариулт орсон байна.

4.3. НАСАНД ХҮРЭГЧДИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Судалгаанд оролцогчид өмнө нь үйл ажиллагаанд оролцож байсан хүүхдүүдийг л дахин дахин оруулдаг гэсэн асуултад тийм гэж 43,7%, хааяа гэж 24,1% нь хариулсан байна. Энэ нь оролцооны туршлагатай хүүхдийг илүү хөгжүүлэх сайн талтай байж болох ч нийт хүүхдүүдийн оролцох боломжийг хязгаарлаж, тэдний оролцоонд хөндлөнгөөс нөлөөлж буй хэрэг юм.

Хүүхэдтэй ажиллаж буй томчууд үгэнд орохгүй байна гэж бие махбодын болон сэтгэл санааны дарамт, шийтгэл хэрэглэдэг гэсэн асуултад тийм гэж 10,9%, хааяа гэж 34,4% нь хариулсан бол үзэл бодлоо илэрхийлсэн хүүхдийг буруутгадаг уу гэсэн асуултад тийм гэж 5,4%, хааяа гэж 30,2% нь хариулсан байна. Энэ бүхэн нь хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, оролцох эрхэд учирч буй томоохон саад бэрхшээл болж байна.

Мөн судалгааны үр дүнд гарч ирсэн дараагийн нэгэн асуудал бол томчууд хүүхдийг сонсдоггүй 53,9%, сонссон ч ач холбогдол өгдөггүй 65,8% нь хариулсан явдал юм. Энэ нь нэг талаас хүүхдийн урам зориг, оролцох хүсэл сонирхлыг мохоож буй хэрэг юм. Нөгөө талаас насанд хүрэгчид оролцооны үндсэн асуудлын нэг болсон хүүхдийг хүлээн зөвшөөрөх /оролцож чадна гэдэг итгэл/ байдал хангалттай биш байгааг харуулж байна.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч хүүхдүүдээс “Та нарт оролцоход ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн асуултад хүүхдүүд мэдээ, мэдээлэл дутагдалтай, мэдэхгүй зүйл их байдаг, хэрхэн яаж оролцохоо мэддэггүй, буруу зүйл хэлбэл загнуулдаг болохоор үзэл бодлоо тэр бүр илэрхийлдэггүй, сургуулийн багш нар томчууд үл тоодог үйлдэл гаргадаг. Бид нарыг шийдвэр гаргалтад оролцоход хангалттай туршлага байхгүй гэж боддог гэж хариулжээ. Энэ нь аливаа арга хэмжээ хаана хэзээ болох цаг хугацааг урьдчилж хэлж мэдэгдэх, оролцох хүүхдийг шүүж сонгох байдлыг халах зэрэг олон бэрхшээлийг дурдаж байгаагаас үзэхэд хүүхэд, насанд хүрэгчдэд оновчтой мэдлэг мэдээллийг системтэй олгож хамтран ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Увс аймгийн төлөөлөл:

“Бүх салбарт хүүхдийн оролцоог хангахад томчуудын хандлагыг өөрчлөх шаардлагатай”

4.4. ОРОЛЦОГЧ ХҮҮХДҮҮДЭЭС ХАМААРСАН АСУУДЛУУД

Судалгаанд оролцсон хүүхдүүд оролцооны талаар мэдлэг ойлголт хомс 23,3%, хэрхэн яаж оролцохоо мэддэггүй 30,1%, хэнд хандахаа мэддэггүй 30,6%, үзэл бодлоо илэрхийлэхээс айдаг 30% гэсэн хариултууд анхаарал татаж байна.

Нийт судалгаанд оролцогчдын 23,3% нь оролцооны талаар мэдлэг ойлголтгүй, 30,1% нь яаж оролцохоо мэдэхгүй байгаа нь мэдээлэл харилцаа холбооны технологи өндөр хөгжсөн өнөө үед тийм бага үзүүлэлт биш юм. Энэ нь хүүхдүүдэд оролцоо гэж юуг хэлдэг, хэрхэн яаж оролцох талаар мэдээлэл, сургалт хэрэгтэй байгааг нэг талаар харуулж байна. Судалгаанд оролцсон 10 хүүхэд тутмын 3 нь үзэл бодлоо илэрхийлэхээс айдаг, хэнд хандахаа мэдэхгүй байгаа нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж буй хүчин зүйл байна.

Насанд хүрэгчдээс “Танай орон нутгийн байгууллагад хүүхдийг оролцуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн нээлттэй асуултыг асуухад хамгийн олон давтамжтай байсан хариултын нэг нь “Сургалт мэдээлэл хүртээмжгүй, хүүхэд хэрхэн яаж оролцохоо мэддэггүй, ойлголт мэдлэг дутмаг, хаана хэнд хандах шат дамжлага ойлгомжгүй” гэсэн байв.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч хүүхдүүд: Мөн хүүхдүүд өөрийнхөө ангид шилдэг нь байсан бол өөр нэг ангид ороод дуугарч чадахгүй болох, ямар нэг танихгүй хүүхдүүдийн хажууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй бусдаас ичих, бусдын өмнө ярихаас айдаг нь бэрхшээл болж байгаагийн хувьд илүү сайн оролцуулж хөгжих, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварт суралцуулах хэрэгцээ байгааг илэрхийлж байна.

Баянхонгор аймгийн Эрдэм ахлах сургуулийн сурагч:

Ямар нэгэн зүйлд оролцох гэхээр өөрсдийн таньж мэдэх хүүхдүүдээ оролцуулдаг.Нэг хоёр удаа саналаа хэлэхэд нээх тоохгүй байхаар сүүлдээ намайг тоодоггүй юм чинь гээд өөрийгөө дайчилдаггүй.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч насанд хүрэгчдээс “Хүүхдийн оролцуулахад тулгардаг бэрхшээл юу байна вэ?” гэсэн асуултад цөөнгүй оролцогчид хүүхдүүд нээлттэй бус, өөрийгөө илэрхийлэх чадвар сул, үзэл бодлоо илэн далангүй илэрхийлж сураагүй, нийгэмшээгүй, хүүхдийн идэвх оролцоо муу байдаг гэж хариулсан.

5. Цаашид анхаарах асуудлууд

Судалгааны ажлын хүрээнд хүүхдүүдээс “Та цаашид ямар орчинд яаж оролцохыг хүсэж байна вэ?” гэсэн нээлттэй асуултыг асуухад дараах чиглэлийн хариултууд хамгийн олон давтамжтай байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг сонссон, тулгамдаж буй асуудалд нь хариулт өгдөг, хамгаалагдсан орчинд оролцох
- Хүүхэд өөрийгөө хөгжүүлэх боломжтой, тав тухтай орчинд оролцох
- Ялгаварлан гадуурхалгүй, дээрэлхэлгүй орчинд оролцох
- Хүүхэд бүрийн саналыг хүлээн авч хэрэгжүүлдэг газар хэрэгтэй байна.
- Техник, технологи хөгжсөн орчинд оролцох
- Сургуулийн шийдвэр гаргах түвшинд оролцох
- Мэдээллийг цаг тулгаж өгдөггүй, мэдээлэл сайн өгдөг орчинд оролцох
- Хичээлээс гадуур олон үйл ажиллагаа зохион байгуулдаг орчинд оролцох
- Үе тэнгийнхэн хоорондоо чөлөөтэй ярилцаж, харилцаж болдог орчинд оролцох

Энэ бүхэн нь хүүхдүүд оролцооны үндсэн асуудлын нэг болсон оролцооны нөхцөл боломжийг бий болгохыг, тэдэнд мэдээллийг нээлттэй ил тод байлгахыг, мэдээллийг тэгш хүртээхийг хүсэж байгааг харуулж байна.

Мөн насанд хүрэгчдээс авсан судалгаанд “Цаашид хүүхдийг оролцуулахад ямар арга хэмжээ авах вэ?” гэсэн нээлттэй асуултыг асуухад оролцогчид дараах чиглэлүүдийг хамгийн олон давтамжтай нэрлэсэн байна. Үүнд:

- Хүүхдийн хүсэл сонирхолд нийцсэн үйл ажиллагаа, уулзалт зэрэг арга хэмжээ зохион байгуулах, түүгээр дамжуулан аль болох тэдний санал бодлыг сонсон ажил хэрэг болгох, түүнийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах
- Нээлттэй ил тод мэдээлэлтэй байх, мэдээллээр хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой гэдгийг ойлгуулах, оролцооны арга хэлбэрт сургах
- Хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг сайжруулах, эцэг эх байх үүрэг хариуцлага хуулийн хүрээнд тогтоож, шаардлагатай тохиолдолд эцэг эх байх эрхийг хасаж, хүүхдийн эрхийг хамгаалах
- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хүүхдийн талаарх чиг үүргийг тодорхой болгох, нэгдсэн зорилго чиглэлтэй хөтөлбөр боловсруулж ажиллах шаардлагатай байна.
- Хүүхдийн асран хамгаалагч, эцэг эхчүүдэд хүүхдийн оролцооны талаар тогтмол мэдээлэл өгч, хүүхдийн оролцоог сурталчлах, эцэг эх олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах
- Хүүхдийн оролцоог хангахад манлайлал нэмэгдүүлэх, удирдагч, манлайлагч хүүхэд олон байвал бусдадаа нөлөөлж чадна. Байнгын холбоо, тасралтгүй үйл ажиллагаанд оролцуулж чадваржуулах, сургах, нөлөөллийн арга хэмжээд оролцуулах гэжээ.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч хүүхдүүдээс “Цаашид яаж оролцохыг хүсэж байна. Юуг өөрчлөхийг хүсэж байна вэ?” гэсэн асуултад хүүхдүүд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, мэдээлэл, хууль эрх зүйн мэдлэг олгох клубт хамрагдах, ялгаварлан гадуурхахгүй эрх тэгш оролцож санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж шийдвэр гаргалтад оролцох боломжийг бүрдүүлж, хүүхдийн санаачилсан ажлыг хэлэлцдэг, эерэг хандлага, зөв бодол, үйлдэлтэй харилцааг хүсдэг болохоо илэрхийлсэн нь томчууд хүүхдийн үзэл бодлыг сайн сонсож, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч насанд хүрэгчдээс “Хүүхдийн оролцоог хангахад цаашид юуг өөрчлөх шаардлагатай вэ?” гэсэн асуултад тэднийг ил тод зөв мэдээллээр хангах, хүүхэд бүрийг сонсох, санал бодлыг хүндэтгэх, эрхийг нь хүлээн зөвшөөрөх, хүүхдийг зоригжуулах, нээлттэй ярилцах, итгэл өгөх, хамгийн чухал нь боловсрол, эрүүл мэндийн байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хүүхдийн оролцоог дэмжиж өөрсдөө хандлагаа өөрчлөх гэж хариулсан.

Мөн хууль дүрэм журам, ялангуяа сургуулийн дотоод журамд хүүхдийг оролцуулах арга замыг тодорхой зааж өгөх, оролцоог дэмжихэд төсөв санхүү хуваарилах, анга танхим орчныг бий болгох, энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг чадавхжуулах, нэмэгдүүлэх зэрэг нь хүүхдийн оролцоог хангахад ач холбогдолтой, хийх шаардлагатай ажлууд гэж үзсэн.

Хүүхдүүд Гэр бүл, Сургууль, Шийдвэр гаргагчдаас юу хүсэж байна вэ?

Төв аймаг Зуун мод IV сургуулийн сурагч, 15 нас эмэгтэй

1. Аав ээжээсээ юу хүсэж байна вэ?

/Зарим хүүхдүүд ээж аавтайгаа тийм ч дотно санагддаггүй./ дотроо бодож санаж явдаг сайн сайхан зүйлээ биелүүлэхийг оролддог боловч хүүхдүүдэд дэмжлэг хэрэгтэй. Энэхүү чуулган нь мөн хүүхэд биднийг дэмжиж байгаа шиг эцэг эх нар маань мөн биднийг дэмжих боломжийг маань ойртуулж өгдөг байгаасай хэмээн хүсэж байна.

2. Засгийн газрын зүгээс юу хүсэж байна вэ?

ЗГ-ууд хүүхдийн санасан бодсон хийж бүтээе гэсэн тэмүүлэлтэй хүүхдүүдийг эдийн засгийн хувиар дэмжлэг өгөөсэй гэж хүсэж байна.

3. Сургуулиас юу хүсэж байна вэ?

Сургууль бүрийг маш сайн мэдлэгтэй багш нартай, эрүүл аюулгүй орчинтой хүүхэд бүрийг хөгжөөсэй гэсэн сэтгэлтэй хүмүүсээр дүүрэн байлгаасай хэмээн хүсэж байна. Мөн ялгаварлан гадуурхалгүй адил тэгш хандлагатай шинэ шинэлэг санаагаар дүүрэн байх. Хүүхдүүдтэйгээ тулж харьцдаг сэтгэл нэгтэйгээр хамтран ажилладаг байх. Хүүхдүүдийн санал бодлыг сонсдог байх, хүүхдүүдэд цаашдаа хэрхэн хөгжих талаар зөвлөгөө өгдөг зэрэг байхыг хүсэж байна.

СХД 13-р хороо “Ирээдүй цогцолбор” ахлах сургуулийн сурагч, 14 нас эмэгтэй

1. Аав, ээжээсээ юу хүсэж байна вэ?

Би аав, ээжээсээ дэмжлэг мөн хайр халамж хүсэж байна. Мөн өсвөр насны хүүхдүүдийн сэтгэлгээг ойлгон, хүндэлж баймаар байна. Мөн дэмжлэг дотроо боловсролын дэмжлэгт түлхүү анхаармаар байна. Хүүхдийнхээ хүсэл сонирхлыг хүндлэх.

2. Засгийн газрын зүгээс юу хүсэж байна вэ?

Засгийн газраас би хэрэгжилтийг хүсэж байна. Бүгд ярьж чадна бүгд л сэтгэж чадна. Гол нь хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн нам төрийн бодлогоос болж дарга цэрэг байнгын солигдож байдгаас болж хүүхдүүд бид сэтгэхүйгээрээ, оюун санаа, бие махбод, мөн боловсролоороо хохирч байна. Бид бүгд тоглоом биш тул бидний эрхийг далд хэлбэрээс зөрчмөөргүй байна. Тиймээс тогтвортой байдал мөн хэрэгжилтийг хүсэж байна.

3. Сургуулиас юу хүсэж байна вэ?

Хүүхдийн аюулгүй байдлыг бүхий л талаас нь хангаж таатай суралцах орчныг бүрдүүлмээр байна. Мөн одоо өнөөгийн нийгэмд хүүхдүүд цаасан дээрх дүнг илүүд үздэг болсон. Энэ тал дээр анхаарч сургалтын чанарыг сайжруулж, сургуульд амьдрах ухааны боловсролыг зааж, төлөвшүүлэхийг хүсэж байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдал, хүүхдүүд болон насанд хүрэгчдийн хүүхдийн оролцооны талаарх ойлголт, байр суурийг тодорхойлох, оролцоонд тулгамдаж буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга замыг тогтоох зорилгоор 2018-2019 онд 2 үе шаттай хийсэн судалгааны үр дүнд дараах үндсэн дүгнэлтүүдийг хийж байна.

Нэг. Хүүхдийн оролцооны талаарх мэдлэг ойлголт

Хүүхдийн оролцооны талаарх мэдлэг ойлголт хүүхдүүд болон насанд хүрэгчдийн хувьд ойролцоо байгаа мэт судалгааны үр дүн /хамгийн оновчтой хариултын хувь 42,5%-45%/ харуулж байгаа ч тэдгээрийг цаашид гүнзгийрүүлэн нээлттэй асуулт, бүлгийн ярилцлагын хэлбэрээр тодруулахад анхаарах асуудлууд байна. Тухайлбал: оролцооны талаарх ойлголт төдийлөн хэлбэршээгүй, оролцоог явцуу хүрээнд ойлгох, оролцооны талаар мэдээлэл, сургалт хангалтгүй зэрэг асуудлууд байна.

Хоёр. Хүүхдийн оролцооны хэлбэрүүд

Судалгаагаар гэр бүлийн болон сургуулийн түвшин дэх оролцооны асуудал болон үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргагчдад нөлөөлөх зэрэг оролцооны хэд хэдэн хэлбэрийн талаар судлан тодорхой үр дүн гарсан. Судалгаанаас харахад хүүхдүүд оролцооны арга хэлбэрүүдийг ашиглах сонирхол, ашигладаг байдал нь боломжийн түвшинд байна. Гэтэл нөгөө талаас хүүхдийн оролцоог хүлээн зөвшөөрөхгүй байх, урлаг, соёл, спортын арга хэмжээнд оролцохоор төсөөлөх, насанд хүрэгчид болон байгууллагын зүгээс хүүхдийн оролцох нөхцөл боломжийг олгохгүй байх зэрэг асуудлууд байсаар байна.

Гурав. Хүүхдийн оролцоонд тулгамдаж буй асуудал

Оролцоонд тулгамдаж буй асуудлуудыг дараах 4-н үндсэн асуудлын хүрээнд авч үзлээ. Үүнд:

- Нийгмийн тогтолцоотой хамааралтай асуудлууд - Энэ нь сургууль, орон нутаг, хүүхдийн оролцооны байгууллага, улс үндэсний болон олон улсын түвшний үйл ажиллагааны болон шийдвэр гаргах, мэдээлэл түгээх зэрэг тогтолцооноос хамаарсан бэрхшээлүүд юм.
- Бодлого, эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудлууд – Хүүхдийн оролцоотой холбоотой үндэсний болон орон нутгийн түвшний бодлого, эрх зүйн баримт бичиг, дүрэм журмын зохицуулалтаас хамаарсан бэрхшээлүүд орж байна.

- Насанд хүрэгчдийн ойлголт, хандлагатай холбоотой асуудлууд – Насанд хүрэгчдийн оролцооны талаарх ойлголт, хүүхдийг хүлээн зөвшөөрөхгүй байх зэрэг нь гол бэрхшээл болж байна.
- Оролцогч хүүхдүүдээс хамаарсан асуудлууд – Энэ нь хүүхдийн оролцооны талаарх мэдлэг, ойлголтгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэхээс ичдэг, айдаг, хэрхэн яаж оролцохоо мэддэггүй зэрэг асуудлууд орно.

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. Хүүхдийн оролцооны бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

- Гэр бүл, сургууль, орон нутаг, үндэсний хэмжээнд, шүүхийн тогтолцоонд хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах, Тухайлбал: шинэ бие даасан бодлогын баримт бичиг боловсруулах, одоо хэрэгжиж байгаа бодлого эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, ялангуяа сургуулийн дүрэм журам, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт болон төсвийн төлөвлөлтөд сурагчдын оролцоог хангах асуудлыг дүрэм журмаар зохицуулах гэх мэт;

2. Хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар хүүхдүүдийн болон үүрэг хүлээгчдийн мэдлэг ойлголтыг сайжруулах

- Хүүхдийн оролцооны тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд хүүхдийн үзэл бодлыг сонсох үүрэг бүхий хүмүүс эцэг эх, шүүх захиргааны ажилтан, багш боловсролын байгууллагын ажилтан, эрүүл мэндийн ажилтан зэрэг хүмүүст хүлээсэн үүрэг эрхэлж буй ажилтай нь холбоотойгоор хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар тохирсон сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, эерэг хандлага уламжлалыг бий болгох; хүүхдүүдэд мөн энэ чиглэлээр тохирсон сургалт хөтөлбөр бий болгох хэрэгжүүлэх;

3. Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх эрхийн хэрэгжилтийг үнэлэх, статистик мэдээлэл цуглуулах арга замыг бий болгох

- Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх эрхийн хэрэгжилтэд хяналт үнэлгээг тогтмол хийх, зөвлөмж гаргах;

- Статистик мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, Тухайлбал засаг захиргааны шийдвэрт нөлөөлөхүйцээр оролцсон хүүхдийн тоо мэдээлэл, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага холбоо, зөвлөлтэй сургуулийн тоо тэнд хамрагддаг хүүхдийн тоо гэх мэт;
4. Олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг бий болгох
- Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд оролцогч талуудад хүүхдэд хамаатай асуудлаар үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр төлөвлөх хэрэгжүүлэх, хянах, үнэлэх зэрэг үе шат бүрд хүүхдийн оролцоог хангах чиглэлээр нөлөөлөл сурталчилгаа хийх;
 - Хүүхдийн амьдралд нөлөөлөхүйц асуудлаар хүүхдэд ээлтэй мэдээлэл боловсруулах, түгээх, ингэхдээ тэдний нас сэтгэхүйн онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэх, хүүхдийн мэдээлэл олж авах боломжийг хүүхдэд ээлтэйгээр бүрдүүлэх;
 - Хүүхдийн оролцооны сайн туршлагыг дэмжих, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийх;
5. Хүүхдийн өөрийн удирдлагын болон оролцооны байгууллагуудыг дэмжих
- Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага нь хүүхдийн хөгжил оролцоонд онцгой үүрэгтэй тул үндэсний бодлого, хөтөлбөрт зорилгыг тодорхойлон дэвшүүлэх;
 - Хүүхэд өсвөр үеийнхэнд өөрийн удирдлагын байгууллагыг авч явах, ажлаа зохион байгуулах мэдлэг чадвар олгох, хүүхдийн оролцох, үзэл бодлоо илэрхийлэх чадвар чадамжийг нэмэгдүүлэх ;
 - Мэдээлэл, материаллаг бааз, санхүү, хөрөнгийн нөөц зэрэг бэрхшээл хомсдол их тохиолдох тул нийгэмд үйлчилдэг ашиг орлогын эх үүсвэргүй хүүхдийн байгууллага, хөдөлгөөний онцлогийг харгалзан төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх;
 - Орчин үеийн хүүхдүүдийн онцлог, эрэлт хэрэгцээг мэдэрсэн удирдлага арга зүйн менежментийн бүтээлч эрэл хайгуул хийх, тогтвортой ажиллах;
 - Сургууль дээрх хүүхдийн сайн дурын санаачилгын клубуудын хамтын ажиллагааг дэмжих, харилцан туршлагаа хуваалцдаг, тухайн асуудлаар нэгдмэл байдлаар дуу хоолойгоо бий болгодог, үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт өгдөг, өөрчлөлтүүдийг бий болгодог байх; Сургууль дээрх нэгдсэн клубийн үйл ажиллагаа нь тодорхой бүтэц, зохион байгуулалт бүхий байхын зэрэгцээ ямар нэг хэм хэмжээнд тогтмол байхад анхаарах нь чухал. Нэгдсэн клуб нь сургуулийн бүх чиглэлийн клубуудын сонирхлыг төлөөлж үйл ажиллагаа хэрэгжүүлэх ба ингэхдээ сургуулийн удирдах зөвлөл, сургуулийн удирдлага, багш сурагчидтай нягт хамтран ажиллана.

НОМ ЗҮЙ

- Child Rights Coalition Asia. (2017). Adult first? A guidebook for child-related professionals and adults to learn about children's right to participation and how to hear the voice of children clearly. Retrieved from https://www.crcasia.org/wp-content/uploads/2018/06/Adult-First_Eng-2017_Web.pdf
- Council of Europe Children's Rights Division and Youth Department. (2016). Child Participation Assessment Tool: Implementation guide.
- EU-UNICEF Child Right Toolkit: Integrating Child Rights in Development Cooperation. 2014. Module 2. Child Rights in Programming and Sector Policies; Module 3. Child Participation.
- IRIM, Британийн Элчин Сайдын Яам, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар, Засаглал дахь хүүхдийн оролцооны өнөөгийн байдал-нийслэлийн түвшинд, УБ, 2013.
- Save the Children. (2015). Mapping and Analysis of Child Participation.
- Terre des hommes-Help for Children in Need. Manual on Child participation including practical toolkit. Germany.
- UNICEF. (2009). The participation of children and young people in UNICEF country programme and national committee activities: Desk review.
- Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам. Хүүхдийн хүмүүжил төлөвшил: Боломж, шийдэл, 2018. МУБИС, БоСС.
- Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам. Хүүхэд залуучуудын хөгжлийн өнөөгийн байдал, 2018
- Ерөнхий боловсролын сургуульд дугуйлан, секц, клуб хичээллүүлэх, багшийн гарын авлага, НҮБ-ын Хүүхдийн Сан, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам. 2016 он
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сургалт судалгаа мэдээллийн төв. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар хийгдсэн судалгааны нэгдсэн лавлагаа (1990-2018), УБ, 2018
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сургалт судалгаа мэдээллийн төв; Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан, УБ, 2018
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар. "Хүүхэд ба шийдэл" эрдэм шинжилгээний бага хуралд ирүүлсэн судалгаанууд.
- Дэлхийн зөн ОУБ. (2005). Хүүхдийн оролцооны сургалт, УБ, 2005.
- Монгол Улсын Засгийн Газар, Үндэсний Статистикийн хороо, НҮБ-ын Хүүхдийн Сан.

- Хүүхэд хөгжил-2010 судалгаа, УБ, 2011.
- НҮБ-ын хүүхдийн сан, Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээ; Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээ-сайн туршлага. УБ, 2013
- НҮБ-ын хүүхдийн сан. Скаутын аргад тулгуурласан хүүхдийн оролцооны хөтөлбөр, УБ, 2009.
- НҮБ-ын хүүхдийн сан. Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн хэрэгжилтийг дүгнэхэд зориулсан гарын авлага.
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №12. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх. (2009)
- ОУ-ын хөдөлмөрийн байгууллага; Хамтран ажиллахад суралцахуй, 2007 он, БИТ ПРЕСС ХХК-д хэвлэв
- Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын хүүхдийн сан. Монгол Улс: Налайх дүүрэг Хүүхэд хөгжил судалгаа-2016. Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа, 2017.
- Хууль Зүй, Дотоод Хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв, НҮБ-ын хүүхдийн сан; Хүүхэд ба хууль ёс, УБ, 2008
- Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос өгсөн зөвлөмжийн эмхэтгэл (1977-2014) ХЭҮК, 2014. УБ
- Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар. Child for Child. Дэлхийн зөн ОУБ. Бүх хүүхдийн эрхийн төлөө: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илгээх хүүхдийн илтгэл. Монгол улс. 2015 он.
- Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл. (2014). Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд 1: Танилцуулга. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар, Дэлхийн Зөн ОУБ хамтран монгол хэл рүү хөрвүүлэв. 2015 он. Улаанбаатар.
- Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл (2014). Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд 2: Хүүхдэд хүндэтгэлтэй, оролцоог хангасан орчин бүрдүүлснийг үнэлж хэмжих тухай гарын авлага. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар, Дэлхийн Зөн ОУБ хамтран монгол хэл рүү хөрвүүлэв. 2015 он. Улаанбаатар.
- Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл. (2014). Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд 3: Хүүхдийн оролцооны цар хүрээ, чанар, үр дүнг хэрхэн хэмжих вэ?. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн

газар, Дэлхийн Зөн ОУБ хамтран монгол хэл рүү хөрвүүлэв. 2015 он. Улаанбаатар.

- Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл (2014). Хүүхдийн оролцоог дүгнэх хяналт, шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслүүд 6: Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газар, Дэлхийн Зөн ОУБ хамтран монгол хэл рүү хөрвүүлэв. 2015 он. Улаанбаатар.
- Хүүхдийн зуслангийн жишиг зардлын тооцоолол, Зөвлөх ажлын тайлан. УБ, 2018
- Хүүхдийн төлөө үндэсний газар, НҮБ-ын хүүхдийн сан. Монголын өсвөр үеийнхний аж байдлын давуу тал болон дэмжлэг.
- Хүүхдийн төлөө үндэсний газар. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг дүгнэх баримт бичгийн эмхэтгэл,. УБ, 2013 он.
- Хүүхдийн эрхийн хороо. 2009. ХЭК-ийн Ерөнхий зөвлөмж №12. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх. CRC/C/GC/12. 2009 оны 07 дугаар сарын 20. Женев.
- Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс. Хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрийн тайлан үр дүн, сайн туршлага, Баянхонгор хот, 2012.

ХАВСРАЛТ

“Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний зөвлөгөөн - 2018” зөвлөгөөнөөс гарсан уриалга

- Хүүхдийн эрхийг хангаж, шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангах журам, хүүхдийн оролцоог дэмжих арга зүй, зураглалыг боловсруулж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулах;
- Засаглалын бүх түвшинд хүүхэдтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хүүхдийн бодит оролцоог дэмжих;
- Сургууль бүрд хүүхдийн оролцооны танхим байгуулж, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, клуб, дугуйлангийн үйл ажиллагаа явуулах төсөв хуваарилах;
- Хүүхэд, өсвөр үеийнхэнд эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах, эх орон байгаль орчноо хайрлан хамгаалах, хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх, эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал чадваруудыг эзэмшүүлэх;
- Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгож, цахим орчинд соёлтой харилцах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг эзэмшүүлж, холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах;
- Хүүхдэд зориулсан мэдээ мэдээлэл, нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлэх, чанартай контент боловсруулж түгээх;
- Гэмт хэрэг зөрчилд холбогдсон, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгэл эдэлж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших, хөгжих, нийгэмших, оролцох эрхийг хангах бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийн оролцоотой хяналт тавих;
- Хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих боломжийг бүрдүүлэхэд анхаарал хандуулж, аймаг, дүүрэг бүрд хүүхдийн хөгжлийн болон спортын орднуудыг төр хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж байгуулах;